

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026.06.25

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв сая.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /эхний хагас жил/	Хүрсэн түвшин
ИРГЭН ТӨВТЭЙ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЖ, БҮТЭЭМЖ, ХАРИУЦЛАГА, ҮР ДҮНГ ТООЦОХ ЖИЛ						
ЗОРИЛГО 1. “ШИНЭ ҮЕИЙН ДИЖИТАЛ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛД СУУРИЛСАН “НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ-360” ЗАГВАРЫГ ХӨГЖҮҮЛНЭ.			ХҮРЭХ ҮР ДҮН: -ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭР “БОЛОВСРУУЛАЛТ-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ-ХЭРЭГЖИЛТ-ҮР НӨЛӨӨ-ХЯНАЛТ” БҮХ ТҮВШИНД НЭЭЛТТЭЙ БОЛНО. -ИЛ ТОД БАЙДЛЫГ ЗӨВХӨН “МЭДЭЭЛЭЛ НИЙТЛЭХ” ТҮВШИНД БИШ, БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ СИСТЕМ БИЙ БОЛСОН БАЙНА. -ХИЙМЭЛ ОЮУНЫ ШИЙДЭЛ НЭВТРҮҮЛСНЭЭР ТӨРИЙН ХҮНД СУРТАЛ, АВЛИГЫН ЭРСДЭЛ БУУРНА.			
Зорилт 1.	Авлига, хүнд суртлыг бууруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахимжуулах, дижитал шилжилт хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангана.	-	Авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт оноо, байр	2025 оны үзүүлэлт 2 дугаар сард зарлагдана.	-	Авлига, хүнд суртлыг бууруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахимжуулах, дижитал шилжилт хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна.
1.1.	Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, ил тод, нээлттэй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид болгох, иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээг бүрэн цахимжуулсан тогтолцоог бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	-	Гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Тооцох %	T%+-	2026 оны эхний хагас жилийн статистик мэдээгээр зөвшөөрлийн 92,7 хувь нь цахим системд ороод байна. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Зөвшөөрлийн зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэх хүрээнд зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулж, цахимжуулсан тогтолцоог бүрдүүлэх шийдвэрийн төслүүдийг боловсруулах хэрэгжилтэд хяналт тавих, зөвшөөрлийн мэдээллийн сангийн бүртгэл, хөгжүүлэлтийн мэдээ, статистикийг гаргуулан хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. Улмаар Зөвшөөрлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Хуулийн төсөлд: 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчлөхөөр тусгаад байна.
			Зөвшөөрөл олгох дундаж хугацаа, хоноогоор	30	25	
			Цахимаар олгож буй зөвшөөрлийн эзлэх хувь	50%	70%+	
1.2.	Зөвшөөрлийн жагсаалтыг жил бүр шинэчлэх, хасах/нэмэх саналыг нэгтгэж Зөвшөөрлийн зөвлөл эсвэл Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, хуульд заасан заавар журмыг боловсруулж, батлуулах	-	Зөвлөл/Засгийн газраар шийдвэрлүүлсэн асуудлын тоо	2	2	Хууль санаачлагчаас ирүүлсэн 4 асуудлын шийдвэрийн төсөл хурлын материалыг бэлтгэсэн боловч Зөвшөөрлийн зөвлөл Засгийн газрын бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор хуралдуулаагүй болно. Зөвшөөрөл шинээр үүсгэхтэй холбогдох аргачлалыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж, яамдын саналыг авч нэгтгэн 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж 155 дугаар тогтоол гаргаад байна.
1.3.	Бүх зөвшөөрлийг “E-License” нэгдсэн платформд нэгтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих		Системд шинээр нэгтгэсэн нийт зөвшөөрлийн тоо	15	20+	Зөвшөөрлийн цахим систем (e-license.mn)-д нийт 371 зөвшөөрлөөс 344 нь бүрэн ороод байна.

1.4.	11-11 төвийн цахим системийг өргөдөл, гомдлын нэгдсэн сантай холбож, хэрэглээнд нэвтрүүлэх, D-gov.mn системийг өргөтгөн хөгжүүлж, тогтоол шийдвэрийн төсөлд санал авах, шийдвэрлэх үйл явцыг шуурхай, ил тод болгох	-	Систем нэвтрүүлэлт, ашиглалтын хувь	50%	70%	11-11 төвийн дуудлага хүлээн авах Dell Edge төхөөрөмжийг амжилттай суурилуулж, хэвийн ажиллагаанд оруулсан бөгөөд дуудлагын физик серверүүдийг cloud орчинд шилжүүлэх ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж байна. Мөн интернэт болон дотоод сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж, 11-11 office болон 11-11 user утасгүй сүлжээний төхөөрөмжүүдийн тасралтгүй ажиллагааг бүрдүүлсэн. Эдгээр ажлын хүрээнд 11-11 төвийн цахим системийг өргөдөл, гомдлын нэгдсэн сантай холбох API хөгжүүлэлтийн суурь нөхцөлийг бүрдүүлж, системийн байнгын ажиллагааг ханган ажиллаж байна. Иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах Засгийн газрын цахим системийн (d-gov.mn/e-zasag.mn) хэвийн ажиллагааг хангаж, системийн функц, хэрэглэгчийн интерфейс, тайлан статистик, байршилд суурилсан үйлчилгээ болон мобайл аппликейшны хөгжүүлэлтийг хийсэн. Мөн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн эрхийн удирдлага болон домэйн нэрийн өөрчлөлтийг хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд нийт 718 санал, санаачилга хүлээн авснаас 242-ыг нийтэлж, 476-г буцаасан бөгөөд 10,239 иргэн системд хандаж, 8,864 удаагийн дэмжлэг үзүүлсэн байна.
1.5.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг хангуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	45%+	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар болон Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсээс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг http://khutulbur.iaac.mn/ цахим системээр авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж журамд заасан хугацаанд баталгаажуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 76%тай үнэлэгдсэн болно. 2025 оны тайланд үнэлгээ хийсний үндсэн дээр 2026 оны төлөвлөгөөг эцэслэн батлуулахаар тогтоон. 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хамтарсан уулзалт хийж, санал, зөвлөмж өгсний дагуу төлөвлөгөөний төсөлд нэгжүүдээс санал авахаар дотоод албан бичгийг хүргүүлээд байна. 2025 оны ХАСХОМ-ийг гаргасан 295 албан хаагч, шинээр томилогдохоор нэр дэвшсэн 149 албан хаагчийн ХАСУМ-ийг хянаж, цахим системд баталгаажуулан, тайлан, мэдээллийг цахимаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Шадар сайд болон Тэргүүн дэд дарга нарт удирдах албан тушаалтны эрхийг нээлгэж, Авлигатай тэмцэх газартай системийн зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлсэн. Салбар эрх бүхий албан тушаалтнуудад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.
1.6.	Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдүүлж, газар өмчлөлийг эрчимжүүлэх ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	-	Гаргасан шийдвэр, хяналт тавьсан ажлын тоо	Тооцох	T+-	Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай, Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай, "Ган үйлдвэрлэлийн цогцолбор" байгуулах Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт хамаарах 651.2 га газрыг үйлдвэрлэл, технологийн паркийн газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолуудыг албажуулсан. "Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2025 оны улсын нэгдсэн тайлангийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж тэмдэглэл гаргасан болно.
			Газар өмчилсөн иргэдийн нийт насанд хүрэгчдэд эзлэх хувь	24.9%	24.95%	
1.7.	Орон нутагт ипотекийн зээлийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод хүргэн хүртээмжийг сайжруулах	-	Орон нутагт ипотекийн зээл авсан хүний тоо	5,291 (2024)	2,200+	Иргэдийн орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын тогтоолын хүрээнд Ерөнхий сайдын 2025 оны 45-р ажлын хэсэг байгуулан "ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО: санхүүжилтийн тогтолцоо, хүртээмж, нийлүүлэлт"-ийг судлан ажиллаж, Орон сууцны санхүүжилтийн банкны тухай болон Орон сууцны нийлүүлэлтийн тухай хуулийн төслүүдийг боловсруулан ажиллаж байна. Харин 21 аймгийн хувьд орон нутагтаа орон сууцны нийлүүлэлт, хүртээмжийг сайжруулахын тулд тогтоолд дурдсан төрөл бүрийн эх сурвалжийг ашиглаж үр дүнтэй ажиллан шинээр орон сууцтай болсон байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар орон нутаг-965, нийслэлд-2617 ипотекийн зээл олгогдсон байна.
Зорилт.2.		-	Ил тод мэдээллийн нийтлэгдсэн хувь	-	70%+	Төрийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод байлгах, тэдний оролцоог нэмэгдүүлж, мэдэх эрхийг хангах хүрээнд 2 хуулийн төсөл боловсруулж, 1

	Төрийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод байлгах, тэдний оролцоог нэмэгдүүлж, мэдэх эрхийг хангана.		Цахим санал асуулгад оролцогчдын тоо	-	T+10%	хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Байгууллагын цахим хуудаст мэдээллийг ил тод байршуулан ажиллаж байна.
			Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%	
2.1.	Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгож, албаны нууцыг байхгүй болгосноор төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх, иргэдийн мэдэх эрхийг хангах зарчмыг хэрэгжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах нөхцөлийг арилгах	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй)	-	тийм	Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн.
			Албаны нууцад авсан асуудлыг ил тод болгох ажлын явц, хувь	-	50%+	
2.2.	Олон нийтийн хяналтын тухай хуулийн төслийг боловсруулах	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй)	-	үгүй	Ерөнхий сайд Г.Занданшатарас өгсөн үүрэг, даалгаврын дагуу хуулийн төслийн тандан судалгаа, үзэл баримтлал, хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж, удирдлагуудад танилцуулсан болно. Хуулийн төслийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт шилжүүлэх, Төр-иргэний хяналтын тухай хуульд нэгтгэн боловсруулахаар удирдлагаас шийдвэрлэсэн тул хуулийн төслийг цаашид дангаар нь боловсруулах шаардлагагүй болсон.
2.3.	Засгийн газар нийгэм, эдийн засгийн томоохон асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цахим хэлбэрээр санал авах, хэлэлцүүлэх нөхцөлийг "И-Монголиа" системд түшиглэн бүрдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	-	Цахим санал авах журамд өөрчлөлт орсон эсэх (тийм/үгүй)	үгүй	тийм	Иргэдийн санал, санаачилгыг хүлээн авах "e-zasag.mn" хэрэглээнд нэвтэрч "Иргэдийн санал санаачилга", "Хэлэлцүүлэг, Ерөнхий сайдаас асууя" булангуудад саналаа илгээх боломжийг бүрдүүлэв. Мөн иргэдийн санал хүсэлтийг 14 хоног тутам "11-11" төвийн өргөдөл гомдолтой нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж байхаар 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас шийдвэрлэсэн. Үүнд: ✓20.000 иргэн саналаа өгвөл Засгийн газраар асуудлыг хэлэлцэнэ. ✓Нийгэм олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлнэ. ✓Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах талбар болгон хөгжүүлж байна.
			Санал авах процесс бүрэн цахим болсон хувь	30%	70%	
2.4.	Иргэн, аж ахуйн нэгжээс төрд байгаа мэдээллийг шаардахгүй байх мэдээллийн жагсаалтыг гаргаж, зохицуулалтын орчныг сайжруулан, цахим хэлбэрт шилжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавих	-	Жагсаалт батлагдсан эсэх (тийм/үгүй)	үгүй	үгүй	Цахим хөгжил, инноац, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн тогтоолын төсөл, танилцуулга, тооцоолол нь шаардлага хангаагүй тул материалыг буцаасан. Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх зохицуулалтыг өргөтгөн тусгасан.
			Холбогдох журамд өөрчлөлт орсон эсэх (тийм/үгүй)	үгүй	үгүй	
2.5.	Мэдээллийн ил тод байдал, вэб сайтын байнгын ажиллагааг хангаж, иргэд олон нийтэд нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх	-	Вэб сайтын байнгын ажиллагаа, мэдээ мэдээллийн хүргэлт, хувь	-	70%+	Тайлант хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим хуудасны хэвийн ажиллагааг хангаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэн ажилласан. Үүнд иргэдийн санал, гомдлын 11-11 төвийн мэдээ, хуулийн төслүүдийн танилцуулга, байгууллагын төлөвлөгөө, тайлан, санхүүгийн мэдээлэл, хүний нөөцийн өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тогтмол нийтэлсэн. Мөн e-zasag.mn системийг холбогдох цахим хуудсуудад байршуулж, shilen.gov.mn системд мэдээлэл оруулах ажлыг зохион байгуулан, харьяа байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
2.6.	"Khural.mn" сайтыг ил тод, ойлгомжтой, боловсронгуй болгож аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг тогтмол мэдээлэх	-	"Khural.mn" сайтыг ил тод нээлттэй, тогтмол мэдээлэх мэдээллийн тоо, давтамж	15586 мэдээлэл	7800 мэдээлэл	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг "Khural.mn" цахим хуудсаар олон нийтэд ил тод, нээлттэй, тогтмол мэдээлэх ажлыг зохион байгуулав. Тайлант хугацаанд 21 аймаг, нийслэлийн Хурлаас нийт 4,977 мэдээлэл оруулсан бөгөөд үүнээс 2,328 нь Хурлын үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, 2,649 нь тогтоол, шийдвэрийн мэдээлэл байв. Төв (779), Өмнөговь (710), Сэлэнгэ (468), Булган (459), Увс (433) аймгуудаас хамгийн идэвхтэй мэдээлэл оруулж ажилласан байна. Системийн цаашдын хэвийн ажиллагааг хангах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, khural.mn системийн ашиглалт, үйлчилгээний

						хувилбаруудыг судлан харьцуулсан дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах санал боловсруулсан. Үйлчилгээ үзүүлэх байгууллагатай гэрээ байгуулах шатанд ажиллаж байна.
2.7.	Төрийн ажил үйлчилгээг анхан шатанд хүргэж буй багийн Засаг дарга нарын чадавхыг бэхжүүлэх ажлын албаны ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, анхан шатны нэгжээр дамжуулан төрийн ажилд орон нутгийн иргэд оролцох боломжийг сайжруулах	-	Сургалтанд хамруулсан багийн Засаг даргын тоо	-	800	Монгол Улсын бүх сум, дүүргийн Засаг дарга 339, бүх баг, хорооны Засаг дарга 1664 хүнийг сургах төлөвлөгөөг 2 хувилбараар боловсруулсан. Үүнд Эхний ээлжинд Удирдлагын академитай хамтран нийт 1647 багийн Засаг дарга нарыг танхимын сургалтад хамруулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийг боловсруулсан. Үүнд 2 өдрөөр, 8 ээлжээр сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нийт 2070.0 сая /2 тэрбум 70 сая/ төгрөгийн тооцоо төсөв гарсан.
ЗОРИЛГО 2. ИРГЭДЭД ЭЭЛТЭЙ, ҮР НӨЛӨӨ БҮХИЙ ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛНЭ.			-ХҮРЭХ ҮР ДҮН: -НИЙТИЙН АЛБА – ЧАДВАРЛАГ, МЭРГЭШСЭН, ТОГТВОРТОЙ ХҮНИЙ НӨӨЦ БИЙ БОЛНО. -ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР МЭДЭГДЭХҮЙЦ САЙЖИРНА. -ЦОМХОН, ҮР АШИГТАЙ, ОНОВЧТОЙ БҮТЭЦ БҮРДЭНЭ.			
Зорилт.3.	Төрийн албаны хууль эрх зүйн орчныг шинэчилнэ.	-	Шинэчлэн батлуулсан хууль, журмын тоо	-	Журам 1	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 1 төсөл, журмын болон дүрэм, аргачлалын 5 төсөл, төрийн албаны мэргэшүүлэх сургалтын 3 багц хөтөлбөрийн шинэчилсэн төсөл, нийт 9 эрх зүйн болон бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан ажилласан.
3.1.	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	үгүй	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хурлаас ирүүлсэн чиглэлийн дагуу намрын чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 51 дүгээр тушаал, Дэд ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 378 дугаар тушаалаар тус тус байгуулан, ажлыг эхлүүлсэн. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх дэд Ажлын хэсэг, Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэх, төрийн албан хаагчийг сургах, мэргэшүүлэх нэгдсэн бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах дэд Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төрийн албаны статистик мэдээлэл, SWOT шинжилгээ, TOWS стратеги болон төрийн албанд тулгамдаж буй 60 орчим асуудлыг нэгтгэн судалж, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Мөн төрийн албаны тухай хуулийг дагалдан мөрдөж байгаа 41 дүрэм, журам, аргачлалд дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах шаардлагатай зохицуулалтыг тодорхойлсон. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн төслийг боловсруулах ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төсөл, үзэл баримтлал холбогдох судалгаа, хуулийн төслийг дагалдуулан нийт 35 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулав. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулав.
3.2.	Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх	-	Шинэчлэн батлуулсан журмын тоо	-	1	Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-д өөрчлөлт оруулах төсөл болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам, аргачлалын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, удирдлагад танилцуулсан. Журам, аргачлалыг шинэчлэх Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, харьцуулсан судалгаа зэргийг боловсруулсан. Засгийн газрын тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуулиудад өөрчлөлт оруулахтай холбогдуулан удирдлагаас тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.

3.3.	Төрийн чиг үүргийн давхардлыг арилгах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд төрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, дахин инженерчлэлийн ажлыг эрчимжүүлэх	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	5%	Улсын Их Хурлын 2025 оны 78 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн зарим байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд хийсэн процессын дахин инженерчлэлийн талаар холбогдох байгууллага, газруудтай 2026 оны 2 дугаар сарын 13 болон 03 дугаар сарын 18, 25-ны өдөр тус тус хэлэлцүүлэг зохион байгуулав. Уулзалт хэлэлцүүлгийн хүрээнд процессын дахин инженерчлэлийг эрчимжүүлэх, зохион байгуулах талаар санал солилцож, 2023 оноос хийгдсэн нийт 6 салбар, төрийн байгууллагад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас хийсэн процессын дахин инженерчлэлийн үр дүнг танилцаж, хэлэлцсэн. Уулзалтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргаас Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт төрөөс олгож буй бизнесийн зөвшөөрлийн үйлчилгээг хялбаршуулах чиглэлээр холбогдох судалгаа хийх, санал танилцуулах чиглэл өгсөн.
Зорилт.4.	Чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ.	-	Удирдах, гүйцэтгэх албан хаагчийн харьцаа, (1 удирдах ажилтанд ногдох гүйцэтгэх ажилтны тоо)	9.2	9.2	Чиг үүргийн шинжилгээгээр удирдах, гүйцэтгэх албан хаагчийн харьцаа шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг тогтоосон.
			Бүтэц, орон тоог шинэчлэн тогтоосон төрийн байгууллагын тоо	-	10+	Байгууллагын бүтэц, чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлагыг судлан тогтоож, 15 яаманд чиглэл өгсөн бөгөөд 1 яам шинэчлэн батлуулсан. Мөн төрийн захиргааны 4 байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хянаж, танилцуулга боловсруулсан.
4.1.	Төрийн болон бүх шатны захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийж, бүтэц, орон тоог оновчтой тогтоох санал, дүгнэлт боловсруулж танилцуулах	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100%	Төрийн болон нутгийн захиргааны 636 байгууллага, 2,577 нэгжийн 39,269 албан тушаал, үүнээс нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг 811 нэгжийн 9,139 орон тоонд, мөн 15 яамны 211 нэгж, 1,751 албан тушаал, 34 агентлаг, 396 харьяа нэгжийн 26,492 орон тоо, 72 улсын төсөвт үйлдвэрийн газрын 4,476 орон тоонд үндсэн чиг үүргийн шинжилгээ хийж, нийт 321 хуудас тайлан, санал, дүгнэлтийг боловсруулан Засгийн газрын хуралдаан болон удирдлагад танилцуулсан. Чиг үүргийн шинжилгээний үр дүнг үндэслэн урт, дунд, богино хугацаанд хийж хэрэгжүүлэх ажил, шийдвэрийн хүрээнд Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжийн төсөл, санал, танилцуулга боловсруулж, удирдлагад танилцуулсан. Үүнээс үе шаттайгаар Засгийн газрын тогтоол, шийдвэрийг гаргуулан ажиллаж байна. Үүнд: 1.Засгийн газрын 2026.04.08-ны өдрийн 119 дүгээр тогтоол, мөн өдрийн Засгийн газрын 13 дугаар хуралдааны 6 дугаар тэмдэглэлийн төсөл боловсруулж, албажуулсан. Тогтоол батлагдсантай холбогдуулан яам, агентлагт, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт чиглэл өгөх "Тогтоол хүргүүлэх тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026.04.15-ны өдрийн ХЭГ/1205 тоот албан бичгийг боловсруулсан. 2.Засгийн газрын 2026.04.15-ны өдрийн хуралдаанд 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг танилцуулж, Засгийн газрын 14 дүгээр хуралдааны 20.3 дугаар тэмдэглэлийн төслийг боловсруулж, албажуулсан. 3.2026.04.09-2026.04.28-ны өдрийн хооронд яамдад хийсэн үндсэн чиг үүргийн шинжилгээний тайланг 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын 18 дугаар хуралдаанд танилцуулсан. Уг хуралдааны 25.1 дүгээр тэмдэглэлийн 2 дахь заалтаар төрийн захиргааны төв байгууллагын нийтлэг чиг үүргийн нэгжийн жишиг бүтцийг тогтоож өгсөн.
			Бүтэц, орон тоог шинэчлэн тогтоосон төрийн байгууллагын тоо	-	10+	Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 25.1 дүгээр хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд (16 яам)-д бүтэц, орон тоог шинэчлэн батлуулах үүрэг чиглэл өгч, чиг үүргийн шинжилгээний үр дүнгээр чиг үүргийг дахин

						хуваарилах, бүтцийг шинэчлэх саналыг яам тус бүрд гарган өгсөн. Үүнээс, Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хянаж, холбогдох саналыг тусгуулан Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 165 дугаар тогтоолоор батлуулав. Мөн 4 байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хянаж, танилцуулга боловсруулсан.
4.2.	"Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг хөгжүүлж, төрийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлэх	Гадаадын зээл, тусламж	Систем нэвтрүүлсэн байгууллагын тоо	-	15+	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим системийг туршилт, зүгшрүүлэлтийн горимоор нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтэц, үйл ажиллагааны онцлогийг харгалзан сонгосон 15 байгууллагад туршилтаар нэвтрүүлэх чиглэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн ХЭГ/09 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2026 оны 03 дугаар сарын байдлаар туршилтад хамрагдсан 15 байгууллагад нэвтрүүлж, 227 нэгжээс 177 нэгж, нийт 1,670 албан хаагчаас 1,359 албан хаагч цахим системээр гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулж батлуулсан. Туршилтын хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөлтийн модулийг бүрэн нэвтрүүлж, 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар туршилтад хамрагдсан 15 байгууллагын Системийн хэрэглэгчдээс ирүүлсэн санал, зөвлөмжид үндэслэн системийг тасралтгүй сайжруулж, хөгжүүлэгч байгууллагатай өдөр тутам хамтран ажилласны үр дүнд гүйцэтгэлийн төлөвлөлтийн модуль 100 хувь, тайлангийн модуль 95 хувь, үнэлгээний модуль 90 гаруй хувийн хөгжүүлэлттэй байна. Цаашид цахим системийг төрийн захиргааны нийт 1,504 байгууллагад үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулсан бөгөөд эхний үе шатанд 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нийт 435 төрийн захиргааны байгууллага, 22,211 төрийн албан хаагчийг хэрэглэгчээр бүртгэн системд нэвтрүүлсэн. Мөн системд Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу эрсдэлийн үнэлгээ хийлгэж, мэдээллийн аюулгүй байдлын шалгалтаар илэрсэн эмзэг байдлыг арилгах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Төрийн захиргааны төв байгууллагуудын хүний нөөц болон гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлан хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулж, хэрэглэгчдэд өдөр тутмын заавар, зөвлөгөө өгч ажилласны үр дүнд 2026 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг цахим системээр зохион байгуулж байна.
4.3.	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын цахим платформын хөгжүүлэх	804.8 сая.төг	Систем хөгжүүлэлтийн хувь	30%	40%	Засгийн газрын хүний нөөцийн мэдээллийн системийн хэрэгцээ шаардлага, өнөөгийн нөхцөл байдлаар талаарх холбогдох мэдээллийг бэлтгэн, удирдлагад танилцуулж, системийг хөгжүүлэх асуудлыг Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд "7.3.2.2.1.Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цогц системийг хөгжүүлж, төрийн байгууллагуудад нэвтрүүлэх" гэж тусган батлуулсан. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд Төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем хөгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цогц систем", "төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын цахим систем"-ийн сайжруулан боловсронгуй болгох ажлын даалгаврыг тус тус боловсруулж, 2026.02.27-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар батлуулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдаж, тендер сонгон шалгаруулах ажил хийгдэж байсан боловч Захиалагчийн шийдвэрээр төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд захиалагчийн хүсэлтээр тендер зохион байгуулах ажлыг түр түдгэлзүүлсэн болно. Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 127 дугаар тогтоолоор Улсын төсвийн зардлаар мэдээллийн систем хөгжүүлэхгүй байх чиглэл гарсантай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсээс тус төсөл арга хэмжээг түр зогсоох чиглэлийг өгсөн болно. Энэ тогтоолд хамаарах эсэх талаар холбогдох мэдээлэл танилцуулгыг бэлтгэн, удирдлагаас чиглэл авахаар хүргүүлсэн бөгөөд хүлээгдэж байна.
4.4.		536.5 сая.төг	Төрийн албаны мэргэшүүлэх багц	-	80%	Төрийн албаны тухай хуулийн 24.1-д төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг Засгийн газар, Төрийн албаны зөвлөл хамтран батлах тухай

			сургалтын хөтөлбөрийн шинэчлэлт, хувь			заасан. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийг 2019 онд баталснаас хойш өөрчлөлт, шинэчлэлт ороогүй. Төрийн байгууллага, албан хаагчдын сургалтын хэрэгцээ, шаардлага, холбогдох судалгаа, шинжилгээний дүгнэлт, санал, гадаад, дотоод орчны өөрчлөлт, шинэчлэлд нийцүүлж төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчилсэн төслийг Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитай хамтран боловсруулсан. Ингэхдээ төрийн захиргааны ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх 3 багц сургалтын агуулга, хөтөлбөрийн төслийг тус бүр шинэчилж боловсруулсан ба албажуулахад бэлэн болсон байдалтай байна. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн түвшингийн судалгаа жилийн эцэст хийгдэх бөгөөд хугацаа болоогүй байна.
	Төрийн албаны сургалтын чанарыг дээшлүүлж, сургалтын цахим системийг хөгжүүлэх		Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин	Тооцох %	T+2%	
			Цахим системийн хөгжүүлэлтийн хувь	-	30%	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цогц системийн хүрээнд Сургалтын нэгдсэн системийн модулийн ажлын даалгаврыг боловсруулж, 2026.02.27-ны өдөр Тэргүүн дэд даргаар батлуулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдаж, тендер сонгон шалгаруулах ажил хийгдэж байсан боловч Захиалагчийн шийдвэрээр төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд захиалагчийн хүсэлтээр тендер зохион байгуулах ажлыг түр түдгэлзүүлсэн болно.
ЗОРИЛГО 3. ТӨРИЙН ӨМЧИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛЖ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ХУРИМТЛАЛ, ҮР ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.			<ul style="list-style-type: none"> - ХҮРЭХ ҮР ДҮН: - ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ӨСӨЛТ, ХУРИМТЛАЛ НЭМЭГДЭНЭ. - ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТӨД ЗЕРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛНЭ. - ТӨХХК-ИЙН ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ САЙЖИРНА. 			
Зорилт.5.	Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулахад дэмжлэг үзүүлж, удирдлага, зохицуулалтаар хангана.	-	Тухайн жилд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ, тэрбум төгрөг	507.114	200.0+	Үндэсний баялгийн сангаар дамжуулж хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэн бүрд хуримтлалын нэрийн дансанд хөрөнгө хуримтлуулахад дэмжлэг үзүүлж, удирдлага, зохицуулалтаар ханган ажилласан.
5.1.	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	үгүй	<p>Ерөнхий сайдын 2025 оны 72 дугаар захирамжаар “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах эсэх асуудлаар санал боловсруулах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг”, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгосон эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг”, “Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг”-ийг тус тус байгуулсан.</p> <p>Ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас санал, мэдээлэл авч нэгтгэн, удирдлагыг шаардлагатай мэдээллээр тогтмол ханган ажиллав.</p> <p>Хуулийн төслийг “Эрдэнэс Монгол” ХХК, “Эдийн засгийн хөгжлийн төв” УТҮГ, Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци болон “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-д хүргүүлж, санал авах ажлыг зохион байгуулсан. Ирүүлсэн санал, дүгнэлтийг нэгтгэн боловсруулж, Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг ханган ажиллаж, хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн боловсруулж, ажлын хэсэг, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төсөл боловсруулах Дэд ажлын хэсгийн нарийн бичиг /Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн газар болон “Эрдэнэс Монгол” ХХК/ нар Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас санаачлан боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Үндэсний</p>

						<p>баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, Уул уурхайн үндэсний ассоциациас Эдийн засгийн хөгжлийн зөвлөлд танилцуулсан. 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26/119 албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн хуулийн төслийн хувилбарыг тус тус харьцуулан судалж, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан болно.</p> <p>Мөн Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай” хуулийн төсөл болон ордын үр өгөөжийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас санал авах, шаардлагатай мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлж, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж байна.</p>
5.2.	Газрын хэвлийн баялгаас иргэдийн хүртэх үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлж, эхний ээлжинд хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг олгоход бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Бортээг, Олон овоот ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоосон эсэх (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Засгийн газрын 2026 оны 48 дугаар тогтоолоор газрын хэвлийн баялгийн өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, одоо болон ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх, сангийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгийг арвижуулах, зүй зохистой зарцуулах асуудлаар иргэдтэй зөвлөлдөж, зөвшилцөлд хүрэх зорилгоор “Монгол хүн - Баялгынхаа эзэн” Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Энэ ажлын хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2026 оны 83 дугаар тушаалаар Дэд ажлын хэсэг байгуулагдаж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Зөвлөлдөх санал асуулгын хамрах хүрээг тодорхойлж, санал асуулгын асуултын төслийг боловсруулсан; - Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд зөвлөлдөх санал асуулгын явц, бэлтгэл ажлын талаар танилцуулж, холбогдох шийдвэрийн дагуу Зөвлөлдөх зөвлөлөөр эцэслэн баталсан асуултын хувилбарыг Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн; - Хоёрдугаар шатны санал асуулгын Зөвлөлдөх уулзалтын хөтөлбөр боловсруулах, уулзалтад ажиллах модераторуудад зориулсан гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлсэн; - Банк, санхүүгийн салбарын төлөөлөл, залуу эрдэмтэн, судлаач, бодлого боловсруулагчдын оролцоотой “Баялгийн сангийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 3 удаа зохион байгуулсан; - Үндэсний статистикийн хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 30-наас 04 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад ажиллаж, санал асуулгын оролцогчдыг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. <p>Зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах хугацаа хойшлогдсонтой холбоотойгоор холбогдох баримт бичиг, материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архивд хүлээлгэн өгсөн.</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа Бортээгийн хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ашиглах төлөвлөгөөний талаар, “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 120 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн хуулийн этгээдүүдээс ирүүлсэн саналыг санхүү, менежментийн чадавх, санхүүжилтийн оновчтой хувилбар, техник, технологи болон бусад шаардлагатай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий Дэд ажлын хэсгийн ажлын явцын талаар Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж, тэмдэглэл гарсан.</p>
			Ажлын гүйцэтгэлийн хувь	Тооцох %	T%+	

5.3.	Стратегийн 17 орд болон томоохон ордуудын өгөөжийг ард иргэдэд шударгаар хүртээх болон үндэсний баялгийн санд орлого төвлөрүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Төгрөг нуур, Төмөртэйн овоо ордыг төрд буцаан авсан эсэх (тийм/үгүй)	үгүй	үгүй	<p>1.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнээс төвлөрөх өгөөжийг Үндэсний баялгийн санд хуваарилах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн төсөл боловсруулахад шаардлагатай мэдээлэл, судалгаа, санал, дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагуудаас авч нэгтгэн боловсруулж, шийдвэрийн төслийн боловсруулалтыг зохион байгуулсан. - Удирдлагыг шаардлагатай мэдээлэл, судалгаа, баримт бичгээр хангах, Засгийн газрын хуралдаанд танилцуулах материалын төслийг боловсруулах ажлыг хэрэгжүүлсэн. - Стратегийн ордод үйл ажиллагаа явуулж буй болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдтэй 10 гаруй удаагийн хэлэлцээ, техникийн уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээлэл, судалгааг нэгтгэн боловсруулан удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох шийдвэр болон эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. <p>Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай хуулийн төсөл болон ордын үр өгөөжийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж байна.</p>
			Стратегийн ордын жагсаалтад оруулахаар судалсан ордын тоо	-	20	<p>2.Мардай, Дорнод, Гурванбулагийн ураны ордууд, Бүрэнхаан, Төмөртэйн овоон ордуудтай холбоотой асуудлаар 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/486 тоот албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлж, холбогдох мэдээллийг авч, нэгтгэн боловсруулсан.</p> <p>2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр стратегийн ач холбогдол бүхий ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй Монгол Улсын Ерөнхий сайдын оролцоотой уулзалтыг зохион байгуулж, төрийн эзэмшлийн 34 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, төвлөрсөн өгөөжийг Үндэсний баялгийн санд хуваарилах эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудлаар санал солилцсон.</p> <p>Тус уулзалтад Мардайн гол ордын ураны нөөц ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч “Адамасмайнинг” ХХК-ийг оролцуулж, төрийн эзэмшлийн 34 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, төвлөрсөн өгөөжийг Үндэсний баялгийн санд хуваарилах эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудлаар санал солилцон, цаашид хамтран ажиллах чиглэлээр харилцан ойлголцолд хүрсэн.</p> <p>Мөн Бүрэнхааны фосфоритын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Топруонхэнцо” ХХК, “Сутайхэнцо” ХХК болон Төмөртэйн-Овоо ордод үйл ажиллагаа явуулж буй “Цайрт Минерал” ХХК оролцож, Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим, түүнээс бий болох үр өгөөжийг одоо болон ирээдүй үеийн иргэн бүрд шударгаар хүртээх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байгаагаа албан бичгээр илэрхийлсэн.</p>
5.4.	Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг олон улсын зарчмуудтай уялдуулан шинэчлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Олон улсын стандарттай нийцсэн байдал, хувь	50%	55%	<p>Үндэсний баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг олон улсын зарчмуудтай уялдуулан шинэчлэхэд бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх хүрээнд холбогдох байгууллага, ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай санал, мэдээлэл, судалгааны материалыг бэлтгэх, нэгтгэх, уялдуулан зохион байгуулах ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>Ерөнхий сайдын 2025 оны 72 дугаар захирамжаар байгуулагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиг үүрэг бүхий ажлын болон</p>

			Сангийн өгөөжийн өсөлт, хувь	4%	4.5%	<p>дэд ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас санал, мэдээлэл авч нэгтгэн, шаардлагатай судалгаа, танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан удирдлагыг мэдээллээр хангаж ажиллав.</p> <p>Хуулийн төслийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, санал авч, саналыг нэгтгэн боловсруулж, Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн хөгжлийн зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаас гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн боловсруулж, ажлын хэсэг, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Дэд ажлын хэсэг болон Уул уурхайн үндэсний ассоциациас Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг олон улсын зарчмуудтай уялдуулан боловсруулж, Эдийн засгийн хөгжлийн зөвлөлд танилцуулсан.</p> <p>2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 26/119 албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн хуулийн төслийн хувилбарыг тус тус харьцуулан судалж, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан болно.</p> <p>Мөн Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай" хуулийн төсөл болон ордын үр өгөөжийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас санал авах, шаардлагатай мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлж, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж байна.</p>
5.5.	Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санхүүгийн ил тод байдал, менежментийг сайжруулахад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Санхүүгийн тайлагналын цахим нээлттэй байдал, хувь	60%	65%	<p>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа, түүнд хуваарилагдсан ногдол ашгийг өвлөх эрхийг нээх, өвлөгчид өвийг шилжүүлэхтэй холбоотой асуудлыг болон "Эрдэнэс Монгол" нэгдлийн үйл ажиллагаанд шаардлагатай түлш шатахууны хэрэглээ, хадгалах агуулах савны өнөөгийн нөхцөл байдлын талаар асуудлыг Засгийн газрын хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэх, танилцуулах бэлтгэл хангуулж, албажуулж ажилласан.</p>
			Алдаагүй тайлагнал, хувь	80%	82%	
5.6.	Оюутолгойн зээлийн хүүг бууруулах, менежментийн төлбөрийг багасгах хэлэлцээ хийхэд дэмжлэг үзүүлэх	-	Зээлийн хүүг бууруулах талаар тохиролцоонд хүрсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	-	<p>Оюу толгой төсөлтэй холбоотойгоор Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн уялдаа холбоог хангаж, шаардлагатай мэдээлэл, зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Төслийн хүрээнд нийт 14 албан бичиг боловсруулж, холбогдох байгууллага, талуудад хүргүүлсэн бөгөөд Ерөнхий сайдын 5 захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 3 тушаал гаргахад шаардлагатай мэдээлэл, санал, судалгаа, дүн шинжилгээгээр ханган ажилласан.</p> <p>Мөн Оюу толгой төслийн хүрээнд хийгдэж буй хэлэлцээ болон хэрэгжилтийн явцын мэдээллийг тухай бүр удирдлагад танилцуулж, шаардлагатай мэдээлэл, дүн шинжилгээ болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>Ажлын хэсгийн төлөөллүүд 2026 оны хагас жилийн байдлаар нийт 4 удаа хуралдаж, Засгийн газрын нууц тогтоолоор байгуулагдсан Оюу толгой төслийн хэлэлцээрийн багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн, 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын 9 дүгээр хуралдаанаар холбогдох өөрчлөлтийг баталсан.</p> <p>Мөн ажлын хэсгүүдээс ирүүлсэн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах хүсэлтийн дагуу Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 94 дүгээр захирамжаар байгуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тус ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 38 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.</p> <p>Хөрөнгө оруулагч талтай хийх хэлэлцээг Засгийн газрын нууц тогтоолоор байгуулагдсан хэлэлцээний багууд нийт 8 удаа зохион байгуулсан бөгөөд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар ахлуулсан хэлэлцээний баг Оюу толгой төслийн менежментийн үйлчилгээний зардлыг хоёр дахин бууруулах асуудлаар</p>
			Менежментийн төлбөрийг бууруулах талаар тохиролцоонд хүрсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	-	

						тохиролцоонд хүрсэн. Сангийн сайдаар ахлуулсан хэлэлцээний баг зээлийн хүүг бууруулах асуудлаарх хэлэлцээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.
5.7.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нүүрсний ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх	-	Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоосон хэлцлийн тоо	1	3	<p>Стратегийн ордод үйл ажиллагаа явуулж буй болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдтэй нийт 3 удаагийн хэлэлцээ, техникийн уулзалтыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Энэ хүрээнд Нарийнсухайтын ордод үйл ажиллагаа явуулж буй “Өсөх зоос” ХХК, “Энержи Ресурс” ХХК, “Хангад Эксплорэйшн” ХХК-тай хийсэн хэлэлцээний үеэр холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, шийдвэрийн төсөл болон Санамж бичгийн төслийг боловсруулах, хэлэлцээний үр дүнг баримтжуулах ажлыг хариуцан гүйцэтгэсэн.</p> <p>Улмаар компанийн төрийн эзэмшлийн 34 хувийг үнэ төлбөргүй шилжүүлэх эсхүл тусгай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах, стратегийн ордын үр өгөөжийн 60 хувийг ард иргэдэд хүртээх, уг хувь хэмжээг жил бүр үнэлж, 60 хувиас буурсан тохиолдолд өгөөж тохируулагч нэмэлт төлбөр төлөх зэрэг зарчмын асуудлаар харилцан тохиролцож, Санамж бичгийг Ерөнхий сайд болон компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.</p> <p>Холбогдох хууль тогтоомжид ордын үр өгөөжийн дийлэнх хэсгийг тодорхойлох зохицуулалт бүрэн тусгагдаагүйгээс шалтгаалан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох хэлэлцээ удааширсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p> <p>Холбогдох хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдсаны дараа стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд эзэмшигч болон түүний үүсмэл ордод үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна.</p>
5.8.	Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг тогтоох хэлэлцээ хийх	-	Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоосон хэлцлийн тоо	-	1	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 101 дүгээр тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсгийн хүрээнд Эрдэнэтийн овоо ордын үүсмэл орд болон холбогдох бусад ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох асуудлаар хэлэлцээ хийх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Хэлэлцээний үр дүнд Эрдэнэтийн овоо ордын үүсмэл ордод үйл ажиллагаа явуулж буй “Ачит Ихт” ХХК-тай зарчмын асуудлуудын хүрээнд харилцан ойлголцолд хүрч, Монгол Улсын Ерөнхий сайд болон тус компанийн хооронд 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр санамж бичгийг байгуулсан.</p> <p>Мөн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ХЭГ/712 дугаар албан бичгээр “Эрдэнэс Монгол” ХХК-иас холбогдох саналыг авч, бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p> <p>Холбогдох хууль тогтоомжид ордын үр өгөөжийн дийлэнх хэсгийг тодорхойлох зохицуулалт бүрэн тусгагдаагүйгээс шалтгаалан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох хэлэлцээ удааширсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p> <p>Түүнчлэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд эзэмшигч болон түүний үүсмэл ордод үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдтэй төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох асуудлаар цаашид авах арга хэмжээний талаар 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “Зэс Эрдэнийн хувь” ХХК, “Эрдмин” ХХК, “Ачит Ихт” ХХК-ийн төлөөллийг оролцуулж, уулзалт зохион байгуулсан. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд эзэмшигч болон түүний үүсмэл ордод үйл</p>

						ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг холбогдох хуулийн төсөл Улсын Их Хурлаар батлагдсаны дараа тогтоох чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж байна.
5.9.	Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын "Орано Майнинг" хувьцаат компани хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжилтэнд хяналт тавих	-	Гэрээний хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хувь	-	50%	<p>Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч Бүгд Найрамдах Франц Улсад бүртгэлтэй "Орано Майнинг" энгийн хувьцаат компани хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцүүлэн боловсруулсан Хувьцаа эзэмшигчийн гэрээнд Монголын талыг төлөөлж гарын үсэг зурах эрхийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал болон "Мон-Атом" ХХК-ийн гүйцэтгэх захиралд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 195 дугаар тогтоолоор олгосон.</p> <p>Үүнтэй холбогдуулан тус гэрээнд талуудын гарын үсэг зурж баталгаажуулах үйл ажиллагааг 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсад бүртгэлтэй "Орано Майнинг" энгийн хувьцаат компани хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээний хүчин төгөлдөр болох өдрийг баталгаажуулахтай холбогдуулан 2 албан бичиг, Засгийн газрын хуралдааны 1 тэмдэглэл, Ерөнхий сайдын 1 захирамж тус тус гаргасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч Бүгд Найрамдах Франц Улсад бүртгэлтэй "Орано Майнинг" энгийн хувьцаат компани хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ хүчин төгөлдөр болох өдрийг бичгээр тогтоохоор тохиролцсоны дагуу 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр "Гэрээ хүчин төгөлдөр болсон тухай мэдэгдэл"-д Монгол Улсын Засгийн газрын төлөөллүүд гарын үсэг зурж, баталгаажуулсанаар хөрөнгө оруулагч төслийн бүтээн байгуулалтын үе шатанд шаардлагатай 500 сая ам.долларын анхны хөрөнгө оруулалт хийх үүргээ хэрэгжүүлэх, бүтээн байгуулалтыг бодитоор эхлүүлэх эрх зүйн боломж бүрдэж, 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр төслийн үйл ажиллагааг албан ёсоор нээсэн.</p> <p>Мөн тус Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан бүтээн байгуулалтын үе шатанд бодлогын дэмжлэг үзүүлэх, салбар дундын уялдаа холбоог хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 52 дугаар тушаалаар байгуулж, удирдамжид заасан асуудлын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад бэлэн болсон.</p>
Зорилт.6.	Томоохон төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангах, эдгээр асуудлаар цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.	-	Хууль, журамд заасан шаардлагыг хангасан, иж бүрдэл бүхий асуудлыг хуралдаанд оруулсан байх (тийм/үгүй)	тийм	тийм	Томоохон төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
			Дэмжлэг үзүүлэн ажиллах төслийн тоо	4	8	
6.1.	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн баяжуулах үйлдвэрийн конвейрын систем	-	Баяжуулах үйлдвэрийн конвейрын системийг ашиглалтад авсан эсэх (тийм/үгүй)	үгүй	тийм	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн тэжээлийн нүүрс тээврийн конвейр, бутлуурын систем, авто ачилтын байгууламжийг ашиглалтад оруулж, нээлтийн ажиллагааг 2026 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд оролцсон. Конвейрийн системийг ашиглалтад оруулахтай холбогдох шаардлагатай мэдээллийг "Эрдэнэс Монгол" ХХК болон "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас авч нэгтгэн, Ерөнхий сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагуудыг мэдээллээр ханган ажилласан.

6.2.	Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах	-	Бортээгийн хэсэгт хөрөнгө оруулж, хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах гэрээ байгуулах (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаартай захирамжаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Бортээгийн хэсэгт хөрөнгө оруулж, хамтран ажиллах асуудлыг хөрөнгө оруулагчдад нээлттэй санал болгох, мэдээлэл хүргүүлэх ажлыг зохион байгуулж, сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс өгсөн үүрэг, даалгаврын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн тушаалаар уг ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулж ажилласан.</p> <p>Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 53 дугаар тогтоолоор Тавантолгой бүлэг ордын ашиглагдаагүй байгаа Бортээг хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхолтой олон улсад нэр хүнд бүхий томоохон аж ахуйн нэгжүүдэд ил тод, нээлттэй зарлан танилцуулж, нээлттэй санал авч, санхүү, эдийн засгийн өгөөж, төсөл хэрэгжүүлсэн туршлага, ордыг цогцоор хөгжүүлэх төлөвлөгөө болон бусад шалгуур үзүүлэлтийг харьцуулан судалсны үндсэн дээр сонгон шалгаруулж, шалгарсан этгээдтэй хэлэлцээ хийхийг үүрэг болгосон.</p> <p>Бортээгийн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хүсэлтэй дотоод, гадаадын 7 аж ахуйн нэгж, консорциум сонгон шалгаруулалтын материалыг худалдан авсан бөгөөд эдгээр 7 аж ахуйн нэгж, консорциум бүгд сонгон шалгаруулалтад оролцох саналаа ирүүлсэн хэдий ч шаардлага хангасан санал ирээгүй.</p> <p>Тус ордод далд уурхайн хөгжлийн стратеги, менежментийн зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, үндэсний туслан гүйцэтгэгч компаниудтай хамтран ордыг ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулах, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгосон. Цаашид “Эрдэнэс Тавантолгой” ХК уурхайн ашиглалтын үйл ажиллагааг хариуцан ажиллана.</p>
6.3.	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл	-	Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	9.53%	45%	<p>Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Хилийн зарим боомтод тээвэр зохион байгуулалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 59 дүгээр тогтоол, "Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд мөрдөх түр журам"-ыг 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор тус тус батлан мөрдүүлж, хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх талаар дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 30.95 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд энэ онд барилгын ажлын гүйцэтгэлийг 80 хувьд хүргэхээр төлөвлөн ажиллаж байна. Ерөнхий гүйцэтгэгчээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн групп" ХХК ажиллаж байна. Уг төслийн хэрэгжилт, мэдээлэлтэй холбоотойгоор бүх талын дэмжлэг үзүүлж ажиллаж байна.</p> <p>"Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн биелэлтийн тайланг нэгтгэн нотлох баримтын хамт 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ХЭГ/2069 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.</p>
6.4.	Гангийн үйлдвэрлэлийн цогцолборын төсөл	-	Газрын асуудлыг шийдвэрлэх (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 56 дугаар захирамжаар “Дархан, Сэлэнгийн бүсийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх болон Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийг</p>

			Урьдчилсан ТЭЗУ боловсруулах (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>боловсруулж батлуулах, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.</p> <p>Тус ажлын хэсгийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал ахалж байсан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 152 дугаар захирамжаар өөрчлөлт оруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням ахлан ажиллаж байна. Ажлын хэсэг байгуулагдсан цагаас хойш Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан.</p>
			Хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Төсөлд хөрөнгө оруулан хамтран ажиллах санал авах урилгыг олон улсад нээлттэй зарлах бэлтгэл ажлын явцыг Ажлын хэсгийн ахлагч Засгийн газрын 2026.04.08-ны өдрийн 13 дугаар хуралдаанд танилцуулсан.</p> <p>Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах хөрөнгө оруулагчийн урьдчилсан сонгон шалгаруулалтын дүнгийн талаар Засгийн газрын 2026 оны 06 сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 25 дугаар хуралдааны тэмдэглэл гарсан. Тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу хураангуй жагаалтад багтсан оролцогчдоос сонгон шалгаруулах Ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.</p>
6.5.	Хөтлийн цемент шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дуусгах	-	ҮТП-ын тусгай зөвшөөрөл авах (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Гүйцэтгэгч тал гэрээнд тусгагдсан ажлын даалгаврын дагуу үйлдвэрийн эскиз зургийг боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Сэлэнгэ аймгийн ерөнхий архитектораар төлөвлөлтийн даалгаврыг батлуулсан. Үйлдвэрийн эскиз зургийн эхний хувилбартай 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Эрдэнэс ҮТП” ХХК болон “Цемент шохой” ХХК танилцаж, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эскиз зурагт нэмэлт, өөрчлөлт оруулах нэгдсэн саналыг гүйцэтгэгч талд хүргүүлсэн. Ийнхүү төслийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах, Монгол хэл рүү хөрвүүлэх ажлууд 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар эцэслэгдэж, “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн зүгээс боловсруулсан зураг төслийг хянан баталгаажуулсны үндсэн дээр 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Барилга хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газарт хүргүүлсэн байна. Төслийн нарийвчилсан зураг төсөл “Барилга хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын экспертизээр хянагдаж, 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр магадлалын нэгдсэн дүгнэлт баталгаажсан. Гэрээт ажлын I үе шат дуусаж, гэрээний дагуу 4,957,023,992.00 төгрөг буюу гэрээний дүнгийн 8.54 хувийг санхүүжүүлсэн байна. Дээрх магадлалын нэгдсэн дүгнэлтэд үндэслэн барилга эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ авах хүсэлтийг хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>
6.6.	Жоншны баяжуулах үйлдвэрийн төсөл	-	ТЭЗУ батлуулах (тийм/үгүй)	үгүй	тийм	<p>Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд хайлуур жоншны хүдрийн баяжуулах үйлдвэр барьж, ашиглалтад оруулах төслийн хэрэгжилтийн явцтай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор холбогдох мэдээллийг цуглуулж, нэгтгэн ажилласан.</p> <p>“Эрдэнэс Критикал Минералс” Төрийн өмчит үйлдвэрийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр барих төсөл”-ийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоёр аж ахуйн нэгжээс төсөлд оролцох санал ирүүлсэн боловч шаардлага хангасан материал ирүүлээгүй.</p> <p>Улмаар “Эрдэнэс Критикал Минералс” Төрийн өмчит үйлдвэрийн газрын Техникийн зөвлөлийн хурлаар төслийг хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцэж, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах хэлбэрээр бус, байгууллагын өөрийн санхүүгийн эх үүсвэрээр, нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг “Эрдэнэс Критикал Минералс” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган батлуулахаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 1/1034 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p>
			Хөрөнгө оруулалтийг шийдвэрлэж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах (тийм/үгүй)	үгүй	тийм	
			Бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	0%	0%	
			ҮТП-ын тусгай зөвшөөрөл авах (тийм, үгүй)	үгүй	тийм	

6.7.	“Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)” төсөл	-	ТЭЗҮ батлуулах (тийм/үгүй)	үгүй	тийм	“Нүүрс химийн цогцолбор (хөх нүүрсний үйлдвэр)” төслийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас тогтмол авч, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Багануур ҮТП” ХХК-аас хэрэгжүүлж буй “Нүүрс-химийн үйлдвэр”-ийн төслийн талаар танилцуулга хийж, хэлэлцсэн. Тус хуралдаанаас гарсан тогтоолоор “Багануур нүүрс-химийн цогцолбор” үйлдвэр, технологийн паркийн хүрээнд хэрэгжүүлэх “Нүүрс-пиролизын үйлдвэр”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хагас коксын хагас үйлдвэрлэлийн туршилтын эцсийн үр дүнг гармагц Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Үндэсний хорооны хуралдаанд танилцуулахыг “Эрдэс Монгол” ХХК-д үүрэг болгосны дагуу холбогдох ажлууд хийгдэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК-тай холбоотой асуудлаар бүх талын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
			Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх (тийм/үгүй)	үгүй	тийм	
			ҮТП-ын тусгай зөвшөөрөл авах (тийм/үгүй)	үгүй	тийм	
			Бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	0%	0%	
6.8.	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах “Зэс боловсруулах цогцолбор” төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Байгуулах гэрээ, хэлэлцээрийн явц, хувь	-	50%	Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах этгээдийг сонгон шалгаруулах тухай асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 2026 оны “Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг батлуулсан. Мөн төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах этгээдийг шалгаруулах сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөлд холбогдох байгууллагуудын саналыг авч тусган, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулсан. Ерөнхий сайдын 2025 оны 60 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг батлуулан, гүйцэтгэчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангасан. Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам”-ын дагуу тус төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах этгээдийг сонгон шалгаруулах ажлыг 2 үе шаттайгаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Сонгон шалгаруулалтын эхний шатанд нийт 7 улсын 13 компани санал ирүүлсэн. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 03 дугаар тушаалаар байгуулагдсан Дэд ажлын хэсэг ирүүлсэн саналуудыг үнэлж, 2 улсын 4 хуулийн этгээдэд мэдэгдэл хүргүүлж, эцсийн шатны сонгон шалгаруулалтад оролцуулах бэлтгэл ажлыг хангасан. Хураангуй жагсаалтад багтсан оролцогчдод сонгон шалгаруулалтын баримт бичгийг хүргүүлснээс 2 хуулийн этгээд заасан хугацаанд санал ирүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 34 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хураангуй жагсаалтад багтаж, материалаа ирүүлсэн 2 хуулийн этгээдээс ирүүлсэн материалыг үнэлж, сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан. Үнэлгээний дүнгээр сонгон шалгаруулалтад оролцсон 2 оролцогчоос БНХАУ-ын “Эн Эф Си” компани хамгийн өндөр үнэлгээ авч, шалгарсан. Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах этгээдийг шалгаруулах сонгон шалгаруулалтын дүнгийн талаар танилцуулсан. Хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах этгээдтэй хэлэлцээ хийх, гэрээний төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар, тус Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг
			ҮТП-ын тусгай зөвшөөрөл авах (тийм/үгүй)	үгүй	тийм	

						бүхий Дэд ажлын хэсгийн Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар тус тус байгуулж, хэлэлцээг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.
Зорилт.7.	Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулна.	-	Төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээний дундаж	T+0.5%	T+0.75%	Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах хүрээнд 2 хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төрийн өмчит компанийг нэгтгэх 3 асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.
7.1.	"Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль", "Нийтийн өмчийн тухай хууль"-ийн төслүүдийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	тийм	Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Мөн Нийтийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүд Улсын Их Хурлын анхны хэлэлцүүлгийн шатанд хэлэлцэгдэж байна. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл хэлэлцэгдэж байгаатай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийг төрийн болон орон нутгийн өмчийн асуудлаар шаардлагатай мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна.
7.2.	Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж (ROA (%) = (Цэвэр ашиг /Нийт хөрөнгийн дундаж) × 100)	9.63%	9.8%	"Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай, "Эрчист Монгол" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг татан буулгах, "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн доголбор" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг зогсоож, "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид нэгтгэх асуудлуудын шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, албажуулсан болно. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн байр, талбайн түрээсийн судалгааг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргуулж, холбогдох танилцуулгыг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргад хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.
7.3.	Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны бүртгэл, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт дэх ил тод байдлын үнэлгээ (улсын дундаж)	-	2.5	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг ашиглалтад оруулсан бөгөөд системийн хөгжүүлэлтийн ажил үргэлжилж байна. Төрийн өмчит хуулийн этгээдүүд системд хандаж, үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллээ бүрэн оруулснаар бүртгэл, мэдээллийн ил тод байдал хангагдах юм. Энэ хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран ажиллаж байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 оны өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг гаргуулан дүгнэх ажил үргэлжилж байна. Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх 5 асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд оруулан албажуулсан.
7.4.	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хөгжүүлэх, хувь	60%	80%	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг 2025 онд ашиглалтад оруулсан бөгөөд одоогоор системийн хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Системийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга болон холбогдох албан хаагчдад танилцуулсан бөгөөд 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газарт мөн танилцуулсан.
			Өмч хөрөнгийн тооллого хийсэн байгууллагын хувь	-	10%	Системийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Системийг ашиглалтад оруулах болон хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай бүхий л дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна. Төрийн өмчийн тооллогын ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

						<p>“Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 238 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>Үүнтэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны даргын 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Мэдээ, тайлангийн маягт, зааварт өөрчлөлт оруулах тухай” А/48 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Маягт, заавар батлах тухай” 87 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” 143 дугаар тогтоол, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А-1/425 дугаар “Улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж, албан даалгавар хүргүүлэх тухай” албан бичгийг тус тус боловсруулан батлуулж, бүх шатны байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Ийнхүү улсын үзлэг, тооллогын ажлыг эхлүүлж, хэрэгжилтийг хангах хүрээнд бүх төрлийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Төрийн өөрийн өмчийн байр, талбайн ашиглалт, түрээсийн гэрээний хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох ажлын үйл ажиллагаанд оролцож, санал дүгнэлт боловсруулсан.</p>
7.5.	Төрийн өмчит зарим компаниудыг олон нийтийн хяналтад оруулах, тодорхой хувийг хувьчлах, өөрчлөн байгуулах, хувьцааг нь нээлттэйгээр биржээр дамжуулан борлуулахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	82%	85%	<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026–2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд 2025 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан төрийн өмчит хуулийн этгээдүүдийн талаар шаардлагатай мэдээллийг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргуулж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар дээрх “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026–2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг буцаан татан авахаар шийдвэрлэсэн байна.</p>
			Батлуулсан тогтоол, шийдвэрийн тоо	0	1	
7.6.	Хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлдэг төрийн өмчийн компаниудад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг сайжруулах	-	Ашигт ажиллагааны түвшин (Үйл ажиллагааны ашиг /Орлого × 100)	Тооцох %	T+6%	<p>“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас Засгийн газрын хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг боловсруулахад оролцсон.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Багануур ХК болон “Зэс боловсруулах цогцолбор” ХХК зэрэг төрийн өмчит аж ахуйн нэгжийн Төлөөлөн удирдах зөвлөлд “Эрдэнэс Монгол” ХХК-д, мөн “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас томилогдох албан хаагчдын нэрсийг “Эрчист Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдийн хурал 2026 оны 4 дүгээр сард болсонтой холбогдуулан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зүгээс холбогдох бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлж ажилласан.</p> <p>Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон “Эрдэнэс Монгол” ХХК, харьяа компаниудын үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчийн эрхийг 100 хувь хэрэгжүүлэгчийн хувиар харьяа төрийн өмчит компаниудад дэмжлэг үзүүлж, ажиллаж байна.</p> <p>Мөн төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний мэдээллийг шинэчлэн гаргаж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.</p>
			Хувьцаа эзэмшигчийн өгөөж (Цэвэр ашиг / Өөрийн хөрөнгө × 100)	Тооцох %	T+4%	
			Хөрөнгийн ашиглалтын үр ашиг (Цэвэр ашиг / Нийт хөрөнгө × 100)	Тооцох %	T+3%	
ЗОРИЛГО 4. САЛБАР БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИНД БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ШИНЭ ТҮВШИНД ХҮРГЭНЭ.			ХҮРЭХ ҮР ДҮН: - ХУРАЛДААНД ОРУУЛЖ БҮЙ АСУУДЛЫН ИЖ БҮРДЭЛ, ЧАНАР, УЯЛДАА НИЙЦЭЛ САЙЖИРНА. - ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ НЭВТЭРСЭН БАЙНА.			
Зорилт. 8.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх, танилцуулах асуудлыг	-	Засгийн газрын хуралдаанд	723	300	414

	бэлтгэх, бодлого, шийдвэрийн уялдааг хангах асуудлаар дүгнэлт, зөвлөмж, санал боловсруулж Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг газрын даргыг ханган, Засгийн газрын хуралдааныг зохион байгуулна.		хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо			
			Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалт /улиралд 1/	12 /сар/	2	1
			Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтын хэрэгжилтийн хувь, өссөн дүнгээр	-	90%+	100%
8.1.	Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, танилцуулах асуудлыг зохих журмын дагуу хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	-	Хууль, журамд заасан шаардлагыг хангасан, иж бүрдэл бүхий хуралдаанд оруулсан асуудлын тоо	723	300+-	Засгийн газрын хуралдаанд яамдаас 2026 оны эхний хагас жилд хэлэлцүүлэхээр ирүүлсэн материалыг Салбарын бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид хянан үзэж, Засгийн газрын хуралдаанд 414 асуудлыг оруулж, шаардлага хангаагүй асуудлыг үндэслэл заан тухай бүр буцаан ажиллав. Оруулсан асуудал салбараар: 1.Гадаад харилцааны яам – 41 асуудал; 2.Эдийн засаг, хөгжлийн яам – 45 асуудал; 3.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам – 15 асуудал; 4.Зам, тээврийн яам – 40 асуудал; 5.Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам – 49 асуудал; 6.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам – 8 асуудал; 7.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам – 14 асуудал; 8.Батлан хамгаалах яам – 25 асуудал; 9.Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудал (Онцгой байдал, бүсчилсэн хөгжил) – 18 асуудал; 10. Эрчим хүчний яам – 11 асуудал; 11. Эрүүл мэндийн яам – 6 асуудал; 12. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам – 20 асуудал; 13. Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудал (Гадаад худалдаа) – 12 асуудал; 14. Сангийн яам – 33 асуудал; 15. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам – 30 асуудал; 16. Боловсролын яам – 17 асуудал; 17. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам – 18 асуудал; 18. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар – 7 асуудал; 19. Хархорум хотын зөвлөл, Захирагчийн ажлын алба – 5 асуудал. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудалд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санал болон яам холбогдох бусад байгууллагаас санал авахаар ирүүлсэн нийт 19 асуудалд Хууль, эрх зүйн газраас санал бэлтгэн, албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан.
8.2.	Засгийн газраас Улсын Их Хурлын 2026 оны ээлжит хаврын болон намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг гарган танилцуулах	-	Жагсаалт батлагдсан эсэх (тийм/гүй)	-	тийм	Засгийн газраас Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтсон болон өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг гарган, тухай бүр шинэчлэн удирдлагад танилцуулж байна.
8.3.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын эрх зүйн үндэслэлийг хянан зөвшөөрөл өгөх, Засгийн газрын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	-	Хянан зөвшөөрөл өгсөн асуудлын тоо	ЗГ-ын тогтоол 472, Тэмдэглэл-691, Захирамж-255	Тухай бүр, гүйцэтгэлээр	Тайлангийн хугацаанд (2026.06.05-ны өдрийн байдлаар) Засгийн газрын 250 тогтоол, 367 Тэмдэглэл, 134 Захирамж нийт 751 асуудлыг хянан, албажуулахад дэмжлэг үзүүлж ажилласан.
			Нийт хянасан асуудлын тоо	1418	Тухай бүр, гүйцэтгэлээр	

8.4.	Засгийн газрын хуралдааныг хэвийн явуулах бэлтгэл хангах, зохион байгуулах, Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах, танхимын үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх	-	Хуралдааны журмын хэрэгжилт хангагдсан хувь	100%	100%	<p>Тайлангийн хугацаанд Засгийн газрын ээлжит 21, ээлжит бус 2, нийт 23 хуралдааны бэлтгэл, өрөө тасалгаа, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, хуралдааны явцыг баримтжуулж, хуралдааныг журмын дагуу зохион байгуулсан.</p> <p>Төрийн тусгай хамгаалалтын газрын Мэдээллийн технологи, тусгай холбооны хэлтэс, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсээр техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, Төрийн тусгай хамгаалалтын газрын Үйлчилгээний хэлтсээр танхимын цэвэрлэгээ, үйлчилгээ, ариун цэврийг хангуулан хуралдааны танхимын бэлтгэлийг бүрэн хангуулж ажиллалаа.</p> <p>Засгийн газрын хуралдаанаар 15 удаа хаалттай, нууц асуудал хэлэлцсэнийг зохион байгуулж, хуралдааны явцыг баримтжуулж, тэмдэглэл хөтөлсөн.</p> <p>Хаалттай хуралдаанаар хэлэлцэх нууцын зэрэглэлтэй 36 асуудлын төслийг хүлээн авч олшруулан, нууцын зэрэглэлтэйгээр гишүүдэд хүргүүлж, бэлтгэл, зохион байгуулалтыг тухай бүр хангаж ажилласан.</p> <p>Засгийн газрын хуралдаанд тараасан нууцын зэрэглэлтэй материалыг буцаан авч, бүртгэж, акт үйлдэн, устгаж ажилласан.</p>
8.5.	Засгийн газрын хуралдааны шийдвэр, тэмдэглэл, хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, архивт шилжүүлэх	-	Албажсан тогтоол шийдвэрийн тоо	ЗГ-ын тогтоол 472 Тэмдэглэл 691 Дэлгэрэнгүй тэмдэглэл...	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>- Засгийн газрын хуралдаанаас гарсан 250 тогтоол, 367 тэмдэглэл, Ерөнхий сайдын 134 захирамж шийдвэр (үүнээс нууц 12 тогтоол, 2 захирамж, 26 тэмдэглэл)-ийн төслийг хянан, холбогдох Засгийн газрын гишүүдээр гарын үсэг зуруулж, албажуулан ажилласан. Шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай хүргүүлж ажилласан.</p> <p>- Засгийн газрын 2026 оны 17 удаагийн хуралдааны 62 цаг 1 минутын бичлэг, 15 удаагийн хуралдаанаар шийдвэрлэсэн 31 асуудлын дэлгэрэнгүй тэмдэглэл, 2025 оны 11 удаагийн хаалттай хуралдаанаар хэлэлцсэн 23 асуудлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус бичиж, албажуулсан.</p> <p>- Засгийн газрын хуралдааны 560 материал болон Засгийн газрын 250 тогтоолын хувийг 20 боть, Ерөнхий сайдын 134 захирамж 3 боть, хуралдааны хураангуй тэмдэглэл 3 боть, хаалттай хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн 36 асуудлыг тус тус архивын нэгж үүсгэн, архивд шилжүүлэхээр ажиллаж байна. Засгийн газрын 11 удаагийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг гарын үсгийн бүрдэл хангуулж, архивд шилжүүлсэн бөгөөд 6 хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг архивд шилжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>- Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн нууц асуудлын тоо, хуралдаанаас гарсан шийдвэр /тогтоол, захирамж, тэмдэглэл, ҮАБЗ-д уламжилсан зэрэг/-ийн мэдээллийг нэгтгэн жагсаалт үйлдсэн.</p>
8.6.	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм, гишүүдийн оролцсон байдал болон хуралдааны журмын хэрэгжилтийн талаар Засгийн газрын хуралдаанд нэгтгэн танилцуулах	-	Хуралдааны тайлан танилцуулсан давтамж	4	2	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм, гишүүдийн оролцсон байдлын талаар статистик мэдээллийг нэгтгэж, удирдлагад танилцуулахаар ажиллаж байна.
8.7.	Засгийн газрын архивын цахим систем, шийдвэрийн цахим систем хөгжүүлж, нэвтрүүлэх төслийн гэрээний хэрэгжилтийг хангах	Төслийн хөрөнгө оруулалт	Гэрээний хэрэгжилтийн хувь	-	-	Засгийн газрын архивын болон шийдвэрийн цахим системийг хөгжүүлж нэвтрүүлэх төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тендер шалгаруулалтыг амжилттай хэрэгжүүлсэн. Гэрээний хэлэлцээрээр хэрэгжүүлэх хугацааг 18 сараас 14 сар болгон бууруулж, 3 жилийн засвар үйлчилгээ болон цахимжуулалтын ажлыг гэрээний нөхцөлд тусган сайжруулсан. Талууд гэрээний төслийг тохиролцсон бөгөөд гэрээг албажуулах шатанд байна.
8.8.	Засгийн газрын хуралдаан зохион байгуулах, хуралдааны шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, хуралдааны явцын тэмдэглэлийг хэлбэржүүлэхэд ашиглах хиймэл оюуны тоног	Төслийн хөрөнгө оруулалт	Гэрээний хэрэгжилтийн хувь	-	50%	<p>Хуралдаан зохион байгуулах хэлтсийн үйл ажиллагаанд шаардлагатай үгийн алдаа засах програм, хиймэл оюун ашиглах эрхийг батлагдсан төсвөөс худалдан авсан.</p> <p>Засгийн газрын үйл ажиллагаанд ашиглах хиймэл оюуны модель, сервер, дагалдах тоног төхөөрөмж худалдан авах төслийн ажлын даалгаврыг боловсруулж, Дэлхийн банкны зөвшөөрлийг авч батлуулсан бөгөөд “Ухаалаг засаг-2” Төслийн удирдах</p>

	төхөөрөмж худалдан авч, суурилуулж, ашиглах					хорооны хуралдаанд танилцуулж, 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан.
Зорилт. 9.	Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн төсөл, бодлогын санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.	-	Боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо	106	55+	1111 шийдвэрийн 3412 заалтыг “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/”-ийн хяналтаас хасах үндэслэлтэй талаар дүгнэсэн.
			Шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчилтэй заалтыг бууруулсан хувь	Тооцох %	T-20%	
9.1.	Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд бие даан боловсруулах хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	-	Хууль, журмын төслийн тоо	УИХ-д өргөн мэдүүлсэн-16	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах хуулийн төслийг боловсруулж байна. Үүнд:</p> <p>1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар хамтран боловсруулсан Төрийн нууцын тухай хуулийн төсөл /Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга/, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын 2026.03.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн;</p> <p>2.Ерөнхий сайдын 2025 оны 65 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан. Мөн хуулийн төслийн үзэл баримтлал, товч танилцуулгыг бэлтгэж, Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлсэн;</p> <p>3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордын үр өгөөжийн дийлэнхийг ард түмэнд хүртээх тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг Засгийн газрын 2026.05.20-ны өдрийн хуралдаанд танилцуулахад бэлтгэсэн. (Хуулийн төсөл боловсруулалтын шатанд байна.)</p> <p>4.Газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Газрын төлбөрийн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Хаягжуулалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2026 оны 128 дугаар захирамжаар байгуулсан. Тайлант хугацаанд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас боловсруулсан хуулийн төслийг хянаж байна.</p>
9.2.	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн захиргааны байгууллагад чиглэсэн хууль, тогтоомжийн төслийг боловсронгуй болгох, холбогдох асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх	-	Хууль, журамд заасан шаардлагыг хангасан, иж бүрдэл бүхий хуралдаанд оруулсан асуудлын тоо	81	40	Орон нутаг, нийслэлийн удирдлагын байгууллагаас шийдвэрлүүлэх шаардлагатай асуудал, Ерөнхий сайдын орон нутагт томилолтоор ажиллахад авах арга хэмжээний талаар, нийслэлийн зарим тулгамдсан асуудлаар болон цаг үеийн шуурхай асуудлаар нийт 20 асуудлыг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж, Засгийн газрын 1 тогтоол, 17 тэмдэглэл, 2 захирамжийг хууль тогтоомж, журамд нийцүүлэн албажуулсан.
9.3.	Төрийн албаны эрх зүйн орчин, хүний нөөцийн болон төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн асуудал, Засгийн газраас томилж, чөлөөлөх албан тушаалтны томилгооны шийдвэрийн төслийг	-	Тогтоол, шийдвэрийн тоо	20	10	Тайлант хугацаанд төрийн албаны хүний нөөц, байгууллагын бүтэц зохион байгуулалт, томилгооны асуудлаар нийт 71 тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулж, хянаж ажилласан бөгөөд үүнээс 67 шийдвэр батлагдсан. Үүнд Засгийн газрын тогтоол 29, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 8, Ерөнхий сайдын захирамж 30 байна.

	боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх					
9.4.	Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө мэдээллээр хангах	-	Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо	5	3	<p>1.Тайлангийн хугацаанд (2026.06.10-ны өдрийн байдлаар) Үндэсний хороо, зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой нийт 10 асуудал Засгийн газрын хуралдаанд хэлэлцэгдэж, холбогдох 10 тогтоол батлагдан албажсан байна. Мөн Засгийн газрын Үндэсний хороо, зөвлөл, комиссуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар өгсөн чиглэлийн дагуу нийт 21 хороо, зөвлөл анхны хурлаа хийж, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан байна. Холбогдох хурлуудад танилцуулах асуудлуудыг урьдчилан хянаж, бэлтгэл ажлыг ханган, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>2.Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо (Ерөнхий сайдын ахалсан)-ны хурлыг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдөр тус Үндэсний хорооны Ажлын албатай хамтран зохион байгуулсан. Мөн хурлаас гарсан Үндэсний хорооны тогтоолын төслийг Засгийн газрын 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан.</p> <p>3.Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл (Ерөнхий сайдын ахалсан)-ийн 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн хурлын зохион байгуулалтыг хариуцан ажиллаж, хурлаар хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, гэр бүлийг дэмжих, хүүхдийн хөгжлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тэгш хүртээмжийг хангах, хүүхдийн зуслан болон хөгжлийн орчны нөхцөлийг сайжруулах зэрэг чиглэлээр нийт 12 заалт бүхий тогтоолын төслийг хэлэлцүүлэн дэмжүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>4.Эдийн Засгийн хөгжлийн зөвлөл (Ерөнхий сайдын ахалсан)-ийн хурлыг 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>
9.5.	Томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн бодлогын хувилбарыг төлөвлөх, санал боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг зохих журмын дагуу хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын саналыг бэлтгэж, удирдлагыг зөвлөгөө мэдээллээр хангах	-	Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудлын тоо	-	2	<p>Засгийн газрын хуралдаанаар нийт 10 асуудал хэлэлцүүлж, танилцуулсан бөгөөд үүний мөрөөр нийт 18 шийдвэрийн баримт бичиг боловсруулж, албажуулсан. Үүнд: Засгийн газрын 4 тогтоол, 8 тэмдэглэл, Ерөнхий сайдын 10 захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 6 тушаал тус тус багтсан. Тухайлбал:</p> <p>1.Оюу толгой төсөл - 1 асуудал хэлэлцүүлж, 7 захирамж, 4 тушаал боловсруулж, албажуулсан.</p> <p>2.Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төсөл - 3 асуудал хэлэлцүүлж, 2 тогтоол, 3 тэмдэглэл, 1 захирамж, 2 тушаал боловсруулж, албажуулсан.</p> <p>3.Гангийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах төсөл - 1 асуудал хэлэлцүүлж, 1 тэмдэглэл боловсруулж, албажуулсан.</p> <p>4.Хөнгөн цагааны аж үйлдвэрийн парк байгуулах төсөл - 1 асуудал хэлэлцүүлж, 1 тэмдэглэл боловсруулж, албажуулсан.</p> <p>5.Стратегийн ач холбогдол бүхий ордны төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох хэлэлцээний явц - 2 асуудал танилцуулж, 2 тэмдэглэл боловсруулж, албажуулсан.</p> <p>6.Засгийн газрын Үндэсний хороо, комисс, зөвлөлийн 3 асуудал хэлэлцүүлж, 2 тогтоол, 2 тэмдэглэл боловсруулж, албажуулсан:</p> <ul style="list-style-type: none"> ● Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл; ● Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөл; ● Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо. <p>7. "Петрочайна дачин тамсаг" ХХК болон "Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт - Ерөнхий сайдын 1 захирамж боловсруулж, албажуулсан.</p> <p>8."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувийн хувьцаатай холбоотой хэлцэл - Ерөнхий сайдын 1 захирамж боловсруулж, албажуулсан.</p>

9.6.	Засгийн газрын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас боловсруулсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	-	Шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчилтэй заалтыг бууруулсан хувь	Тооцох %	T-20%	Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, албан даалгаврыг тухай бүр хяналтад авч, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан /new.unelgee.gov.mn/-д байршуулан ажиллаж байна. Тэргүүн дэд даргын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 23 дугаар тушаалаар төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг оролцуулан Засгийн газрын шийдвэрийн 2025 жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Ажлын хэсэг байгуулан ажилласан. Тус Ажлын хэсэг хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар танилцуулан 07 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр авч үзвэл: 1.Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д бүртгэлтэй Засгийн газрын 574 тогтоолын 1210 заалт, Засгийн газрын хуралдааны 223 тэмдэглэлээр үүрэг чиглэл өгсөн 1565 заалт, Засгийн газрын 17 албан даалгаврын 669 заалт, Ерөнхий сайдын 96 захирамжийн 114 заалт, нийт 910 шийдвэрийн 3558 заалтын хэрэгжилт дунджаар 73.54 хувьтай байна. 2025 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 1111 шийдвэрийн 3412 заалтыг “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/”-ийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж салбарууд дүгнэсэн байна.
9.7.	Удирдлагын шийдвэрийн дагуу Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллагад төлөөлөх, тайлбар, мэдээллийг бэлтгэн, хүргүүлэх	-	Олгосон итгэмжлэлийн тоо	40	Тухай бүр, гүйцэтгэлээр	Үндсэн хуулийн цэцээс иргэний гаргасан гомдолтой холбогдуулан болон бусад асуудлаар тайлбар ирүүлэх тухай 4 албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсний дагуу холбогдох тайлбарыг бэлтгэн, албан бичгээр хүргүүлэв.
			Нотлох баримтын хүсэлтийг хангасан тоо	102	Тухай бүр, гүйцэтгэлээр	1.Шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын 47 удаагийн хүсэлтээр хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын архиваас зохих зөвшөөрлийн дагуу гаргаж, хүргүүлэх ажлыг зохион байгуулсан. 2.Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдад холбогдох иргэний болон захиргааны хэрэгт төлөөлөн оролцох этгээдэд Монгол Улсын Ерөнхий сайдын 40 удаагийн захирамжаар итгэмжлэл олгон ажилласан.
9.8.	Монгол Улсын харьяат болох, Монгол Улсын харьяатаас гарах, харьяатаа сэргээн тогтоолгох асуудлыг хянах, Ерөнхий сайдад танилцуулах	-	Танилцуулсан, буцаасан хүсэлтийн тоо	150	100	2026 оны эхний хагас жилд Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 35 иргэний баримт бичгийг хууль журмын дагуу хянаж, Ерөнхий сайдад танилцуулж, хариуг хүргүүлсэн. Харьяалал сэргээн тогтоолгох 2, харьяат болох 6 иргэний материалд Гадаадын иргэн, харьяатын газраас нэмэлт тайлбар, нотлох баримт гаргуулах ажиллагаа хийж байна.
9.9.	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлын шийдвэр гаргалтад бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	-	Гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн хувь	Тооцох	T+5%	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, бодлогын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн шийдвэр гаргалтын үндэслэлийг бүрдүүлэв. Төрийн захиргааны төв байгууллагуудад хийсэн чиг үүргийн шинжилгээний үр дүнд 11 яамнаас нийт 72 чиг үүргийг шилжүүлэх боломжийг тодорхойлноос 38 чиг үүргийг агентлагт, 23 чиг үүргийг харьяа байгууллагад, 11 чиг үүргийг төрийн бус байгууллага болон хувийн хэвшилд шилжүүлэх боломжтойг тогтоосон. Мөн төрийн захиргааны байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газруудад хийсэн шинжилгээгээр 9 агентлагийн хэрэгжүүлж буй 35 чиг үүргийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хуулийн этгээдэд шилжүүлэх боломжтойг тодорхойлон удирдлагад танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны 25.1 дүгээр тэмдэглэлийн 3 дахь заалтаар төрийн захиргааны төв байгууллагад хэрэгжиж буй зарим гүйцэтгэх чиг үүргийг шилжүүлэх саналаа ирүүлэхийг холбогдох сайд нарт даалгасан шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг эхлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

						<p>Түүнчлэн Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 24 дүгээр хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн хүрээнд 2022-2025 онд төрийн байгууллагуудаас хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, бодлогын танилцуулгыг боловсруулан удирдлагад хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын дэвшүүлсэн "Чөлөөлье" санаачилгын хүрээнд төрөөс бизнес эрхлэгчдэд учруулж байгаа дарамт, хүнд суртлыг арилгах, төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх санал, жагсаалтыг авахаар ХЭГ/1862 дугаартай албан бичгийг хүргүүлэн яам, агентлагийн саналыг нэгтгэж байна.</p>
9.10.	Хувийн өмчийн халдашгүй байдлыг төрөөс бүрэн хамгаалж, бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, хууль бусаар өмч хураах, албадан хариуцлага хүлээлгэхийг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлэх	-	Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексийн Өмчийн эрх дэд үзүүлэлтийн байр	94/184	-	<p>Засгийн газраас Бизнесийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p> <p>Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хадгалж, ерхийн бодит орлогыг нэмэгдүүлэх хүрээнд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 104 арга хэмжээ бүхий Ерөнхий сайдын албан даалгаврын төслийг бэлтгэн Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанд танилцуулж, 04 дүгээр албан даалгавар гарсан. Тус албан даалгаварт төрийн албан хаагчийн чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн өмчит хуулийн этгээдийг нэгтгэх, хувьцааг арилжаалах талаар даалгавруудыг тусгасан.</p>
Зорилт.10.	Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ.	-	Хууль, шийдвэрийн хэрэгжилтийн хувь (Бүрэн хэрэгжсэн актын тоо / Хяналтад авсан актын нийт тоо × 100)	Тооцох %	45%+	Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ.
			Хугацаандаа хэрэгжсэн шийдвэрийн хувь (Хугацаандаа хэрэгжсэн акт / Нийт акт × 100)	Тооцох %	70%+	
10.1.	Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	-	Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын даргын тушаалаар сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулагдсан Ажлын хэсгийн тооны дундаж	9	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын газар, нэгжүүдийн албан хаагчид хариуцсан чиг үүргийн дагуу Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Тэргүүн дэд дарга болон бусад байгууллагын шийдвэрээр байгуулагдсан 40 гаруй ажлын хэсэгт оролцож, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, нэгдсэн удирдлага, зохицуулалт, арга зүйн дэмжлэгээр ханган ажилласан.</p> <p>- Салбарын бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид Газрын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах, "Богдхан төмөр зам" төсөлтэй холбоотой мэдээллийг ил болгох асуудлаар санал, дүгнэлт боловсруулах, хөдөлмөр, нийгмийн түншлэлийн улсын хэлэлцээр байгуулах, "Зөвлөлдөн шийдье" зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулах зэрэг ажлын хэсгүүдэд оролцож ажиллав.</p> <p>- Хууль, эрх зүйн газрын албан хаагчид төрийн албаны эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, ёс зүй, цалин хөлс, хүний нөөцийн бодлоготой холбоотой хуулийн төсөл, үзэл баримтлал, судалгааг боловсруулах дэд ажлын хэсгүүдэд ажиллав.</p> <p>- Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын удирдлага, албан хаагчид төрийн өмчийн байр ашиглалтын үнэлгээ хийх, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаатай холбоотой Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах, Гашуунсухайт боомтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, Хархорум хотын бүтээн байгуулалтын ажилд хяналт тавих, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжих арга хэмжээг зохион байгуулах зэрэг ажлын хэсгүүдэд ажиллав.</p> <p>- Засгийн газрын хүний нөөцийн газрын удирдлага, албан хаагчид төрийн албаны хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төрийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, байгууллагын 2026 оны төлөвлөгөөг боловсруулах, төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны эрх зүйн орчныг</p>
			Ажлын хэсгийн зорилт хангагдсан хувь	Тооцох %	90%+	

						<p>боловсронгуй болгох, төрийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэгтэй нэгжийн чиг үүргийн шинжилгээ хийх, гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдыг сонгон шалгаруулах зэрэг чиглэлээр байгуулагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл болон бусад байгууллагын нийт 12 ажлын хэсэгт ажиллаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэв.</p> <p>- Захиргаа, зохион байгуулалтын газрын албан хаагчид төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн системийн тендерийн үнэлгээний хороо, "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд систем, тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсэг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх, шийдвэрийн биелэлтийг их өгөгдөл болон хиймэл оюун ухаанд суурилсан аргачлалаар үнэлэх ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүнд Засгийн газраас нэр дэвшүүлэх нэр дэвшигчийг сонгон шалгаруулах Ажлын хэсэг болон бусад ажлын хэсгүүдэд ажиллаж, холбогдох арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэв.</p> <p>- Төсөл хөтөлбөр, гэрээ хэлэлцээрийн газрын албан хаагчид Оюу толгой төсөл, Монгол - Францын хамтарсан ураны төсөл, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа өвлүүлэх асуудал, зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төсөл зэрэгтэй холбоотой төсөл, хөтөлбөр болон салбар дундын асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий нийт 16 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Санхүү, хөрөнгө оруулалтын газрын албан хаагчид "Төрийн өмчит компанийг татан буулгах тухай" Засгийн газрын 2026 оны 91 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд "Эрчис Монгол" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хурлын 2026 оны 02 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсэг болон гэрээний дагуу нийлүүлэх техник хэрэгслийн акт, баримтаар хүлээн авах 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.</p>
10.2.	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг яам, Засгийн газрын агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих	-	Хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн хувь (Бүрэн хэрэгжсэн актын тоо / Хяналтад авсан актын нийт тоо × 100)	Тооцох %	T%+	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг яам, Засгийн газрын агентлагийн түвшинд уялдуулан зохицуулах арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна.
			Хугацаандаа хэрэгжсэн шийдвэрийн хувь	Тооцох %	T+5%	
10.3.	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газрын байгууллагуудын хүрээнд зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар хангах	-	Яам, Засгийн газрын агентлагуудын Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	-	60%+	<p>Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах хүрээнд төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд өөрчлөлт оруулах Засгийн газрын 210 дугаар тогтоол, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 119 дүгээр тогтоол, төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын шинэчилсэн найруулга, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны ангилалд адилтган үзэх албан тушаалын жагсаалтад өөрчлөлт оруулах асуудал зэрэг шийдвэрүүдийг боловсруулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан. Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, онцгой байдал, дотоодын цэргийн салбарын нэмэгдэл, урамшуулалтай холбоотой журмын төсөлд хяналт хийж, санал боловсруулсан.</p> <p>Засгийн газрын 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 15 яам, 34 агентлаг, 396 харьяа газар, хэлтэс, 72 улсын төсөвт үйлдвэрийн газрын чиг үүргийн шинжилгээг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Үүний үр дүнд төрийн байгууллагуудад цагийн уян хатан зохицуулалт нэвтэрч, төрийн албан хаагчийг зайнаас ажиллуулах нийтлэг аргачлал батлагдан, төрийн албан хаагчдыг "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д нэвтрэх эрхээр хангах арга хэмжээ хэрэгжсэн.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй 8 багц асуудлыг тодорхойлон санал боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо болон холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Мөн төрийн байгууллагуудын Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг дэмжиж,</p>

						<p>2025 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланг нэгтгэн хүргүүлж, ёс зүйн зөрчилтэй холбоотой 48 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн 91 байгууллагын 210 төлөөлөгч оролцсон Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, уулзалтад оролцсон.</p> <p>Төрийн албаны зэрэг дэвийн асуудлаар Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн саналыг нягтлан шалгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн нийт 55 албан хаагчид тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах санал, 166 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох Ерөнхий сайдын 118 дугаар захирамжийг тус тус гаргуулсан.</p> <p>Мөн жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан хүргүүлж, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээнд байгууллагыг төлөөлөн албан хаагч оролцсон. НҮБ-ын 2026 оны Төрийн албаны чуулганд оролцох бэлтгэл ажлыг хангаж, холбогдох танилцуулга, бүртгэл, зохион байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газраас томилогддог албан тушаалтнуудын ХАСХОМ-той холбоотой 5 төрлийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 63 иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 153 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авч баталгаажуулсан бөгөөд мэдүүлэг гаргагчдын нэгдсэн жагсаалтыг шинэчлэн хүргүүлсэн.</p>
10.4.	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг зохион байгуулах	-	Бэлтгэл хангах ажлын гүйцэтгэлийн хувь	-	50%+	<p>Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаагаар хойшлуулсан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 65 дугаар захирамжаар хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангах санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулан байгуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ерөнхий сайдын 2025.12.02-ны өдрийн 155 дугаар захирамжаар ажлын хэсгийг шинэчилсэн. Ажлын хэсгийн хурлыг Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газраас нийт 4 удаа хийлгэсэн. Засгийн газрын хуралд танилцуулах 3 хувилбар, шийдлийн саналыг боловсруулж, холбогдох үр дагаврын судалгааг хийсэн. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн зарим заалтын хугацааг хойшлуулах асуудлын үзэл баримтлал, танилцуулгыг хийж Засгийн газрын 2026.03.11-ний өдрийн хуралд танилцуулсан. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарч Улсын Их Хуралд танилцуулгыг хүргэж, хуулийн төслийн зохих судалгааны ажлыг хийсэн. Ерөнхий сайдын 2026.04.28-ны өдрийн 93 дугаар захирамжаар ажлын хэсгийг дахин байгуулж, Засгийн газрын хуралд саналын хувилбаруудыг 2 удаа танилцуулж, хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хууль, тогтоолын төслийг хаврын чуулганд багтаан хэлэлцэхээр шийдвэрлээд байна.</p>
10.5.	Аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, Засгийн газрын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	-	Дэмжлэг үзүүлж ажилласан Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх зарим агентлагийн тоо	18 аймаг, 20 сумын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх зарим агентлаг	9 аймаг	<p>Хөвсгөл, Дорноговь, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Ховд, Баян-Өлгий, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгуудад болон Нийслэлийн Багануур, Багахангай, Сүхбаатар дүүрэгт хариуцсан ажилтнууд нийт 18 аймаг, 16 суманд ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. Мөн 2026 оны 4 дүгээр сарын 2–8-ны өдрүүдэд Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын даргаар ахлуулсан аймгуудын Засаг дарга нарын төлөөлөл Бүгд Найрамдах Узбекистан Улсад албан томилолтоор ажиллаж, хөдөө аж ахуй, усны аж ахуй, ногоон эрчим хүч, инновацын чиглэлээр холбогдох байгууллагуудтай уулзалт хийж туршлага судалсан. Үүний үр дүнд мал нийлүүлэх, жимс жимсгэний аж ахуй байгуулах, усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, таримлын зохистой бүтцийг тодорхойлох, загасны аж ахуй хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар урьдчилсан байдлаар тохиролцсон. 2026 оны 5 дугаар сарын 16–21-ний өдрүүдэд Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын даргаар ахлуулсан аймгуудын удирдлага болон орон нутгийн аж ахуйн нэгжийн төлөөлөл Хармөрөн мужид хийсэн томилолтоор төлөөлөгчид үйлдвэрлэл,</p>

						халаалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрүүд болон үзэсгэлэнтэй танилцаж, дулаан үйлдвэрлэлийн чиглэлээр хамтын ажиллагааны үндэс тавив. Үүний үр дүнд Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ аймагт Дулааны цахилгаан станц барих, орон нутгийн дулааны эх үүсвэрийг сайжруулах хүрээнд БНХАУ-ын үйлдвэрүүдтэй шууд хамтран ажиллахаар тохиролцож, Арвайхээр хотын 35МВт Дулааны цахилгаан станцын урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлтэй танилцан хэрэгжүүлэх боломжийг тодорхойлов. Бүгд Найрамдах Узбекистан Улсын төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал 2026 оны 06 дугаар сарын 07-13-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэв.
			Боловсруулсан бодлогын хувилбар, саналын тоо	3	2	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 119, 127 дугаар тогтоол болон хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар, албан даалгаврыг тухай бүр аймаг, орон нутгийн удирдлагуудад хүргэн, хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг чиглэл болгон зөвлөмж өгөн ажиллаж байна. Аймгуудыг гадаад хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарт хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх, технологи, хөрөнгө оруулалтыг татах талаар зөвлөмж өгөн ажиллаж байна
10.6.	Орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх болон хууль хэрэглээний хүрээнд гарч байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх судалгааг хийж холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг зохих төрийн байгууллагуудтай хамтран боловсруулж танилцуулах	-	Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хийсэн судалгааны ажлын тоо	4	2	Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолд тусгагдсан төвлөрлийг сааруулах, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэх бодлогын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг судалж удирдлагуудад танилцуулав. Энэхүү асуудлыг судлахдаа 5 төрлийн эх сурвалжийг ашигласан бөгөөд нийт 15 асуудлыг багцалж гаргасан. Эдгээр асуудлуудыг судалж шийдвэрлэхийг Засгийн газрын 2026 оны 4, 5, 7, 9 дүгээр хуралдааны тэмдэглэлүүдээр холбогдох сайд нарт үүрэг болгосон. Орон нутгийн тулгамдсан асуудлын чиглэлээр дээрх 15 багц асуудлын талаар аймгийн Засаг дарга нарыг оролцуулсан Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг 2026 оны 06 дугаар сарын сүүлчээр зохион байгуулахаар төлөвлөөд байна. Тухайбал: Газрын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль гэх мэт хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох яамдаас судалж байна. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг байгууллагуудын удирдлагыг хэвтээ томилгоотой болгох асуудлыг судалж байна.
10.7.	Баг, хорооны Засаг даргад Засгийн газрын бодлого, шийдвэрийг тухай бүр шуурхай хүргэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	-	Мэдээллийг шуурхай хүргэх тогтолцоо бүрдсэн эсэх (тийм/үгүй)	үгүй	тийм	Баг, хорооны Засаг даргад Засгийн газрын бодлого, шийдвэрийг тухай бүр шуурхай хүргэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд аймаг, орон нутгийн удирдлагуудтай эргэх холбоотой ажиллаж, мэдээллийг түргэн шуурхай хүргэх, ажил хэрэгч санал санаачлага, орон нутгийн нөхцөл байдлын талаарх мэдээг цаг алдалгүй авах зорилгоор сум, багийн Засаг дарга нарыг бүсээр нь ангилж Фейсбоок групп нээж, Засгийн газрын бодлого, шийдвэрийг тухай бүр шуурхай хүргэх мэдээллийн тогтолцоог бүрдүүлэв. Тогтоол, шийдвэрийг баг, хорооны Засаг даргад ажлын 3 өдөрт багтаан хүргэдэг болсон.
			Тогтоол, шийдвэрийг баг, хорооны Засаг даргад хүргэх хугацаа	-	Ажлын 3 өдөр	
10.8.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, салбаруудын эрх зүйн орчныг шинэчлэх, төрийн албан дахь хүйсийн тэнцвэрт байдлыг хангах ажлын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	-	Жендэрийн тэгш байдлыг хангах зарчим, агуулга тусгагдсан салбарын хууль тогтоомжийн тоо	6	6	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгааны дүн болон хуулийн хэрэгжилтийг хангах талаарх санал, зөвлөмж, статистик мэдээг яамд, агентлагуудад хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчдын 64.28 хувь буюу 137312 нь эмэгтэй, 35.72 хувь буюу 76299 нь эрэгтэй байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1-т "томилгодох төрийн улс төрийн албан тушаалтын дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас доошгүй байх"-аар тусгагдсан. Засгийн газрын сайд нарын хүйсийн харьцаа эмэгтэй 11 хувь, эрэгтэй 89 хувьтай байна. Төрийн албаны эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журмыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд

			Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотын хэрэгжилтийн хувь	50%	60%	нийцүүлэн шинэчлэх, хэрэгцээ, шаардлагыг тандан судлах бэлтгэл ажлыг хангаж байна. Төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, хэрэгжүүлэх талаар төрийн албан хаагчдад жендэрийн мэдрэмжтэй сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого"-ыг 2026-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооны ээлжит хуралдааныг 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Төрийн ордны "Их эзэн Чингис хаан танхим"-д зохион байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тус хуралдаанаас хэлэлцэн баталсан 2 тогтоолын төслийг хянан, албажуулж ажилласан.
Зорилт.11.	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт, гүйцэтгэлийг улсын хэмжээнд нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ.	-	Хяналтад байгаа заалтын тоо	5600	T+-	Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д бүртгэлтэй 1348 шийдвэрийн 5688 заалт байна. 1111 шийдвэрийн 3412 заалтыг "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/"-ийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж салбарууд дүгнэсэн.
			Хяналтад авсан, хяналтаас хассан заалтын тоо	Тооцох	T+-	
			Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн тоо	0	1	
11.1.	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж, мэргэшил арга зүйгээр хангах, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн тоо	0	1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт даалгасан, үүрэг, чиглэл болгосон хууль, Улсын Их Хурлын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газар болон Ерөнхий сайдын албан даалгаврыг тухай бүр хяналтад авч Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан /lgovernment.mn/-д Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын нэгж тус бүрээр байршуулав. "Ажлын хэсэг байгуулах тухай" Тэргүүн дэд даргын 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 23 дугаар тушаалаар төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг оролцуулан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар танилцуулан 07 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн. Түүнчлэн хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг 2026 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд. 1.Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д бүртгэлтэй хууль тогтоомж, тогтоолын 1348 шийдвэрийн 5688 заалтын хэрэгжилт дунджаар 73.98 хувь байна. 2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 10 төрлийн шийдвэрийг үндсэн 3 хэсэгт ангилан нэгтгэн дүгнэхэд: -Монгол Улсын 134 хуулийн 540 заалт, Улсын Их Хурлын 158 тогтоолын 864 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 93 тогтоолын 573 заалт, нийт 385 шийдвэрийн 1977 заалтын хэрэгжилт дунджаар 77.17 хувь; -Монгол Улсын Ерөнхийлөгчийн 20 зарлигийн 61 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 21 зөвлөмжийн 80 заалт, тус зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр үүрэг

						чиглэл өгсөн 8 шийдвэрийн 12 заалт, нийт 49 шийдвэрийн 153 заалтын хэрэгжилт дунджаар 74.37 хувь; -Засгийн газрын 574 тогтоолын 1210 заалт, Засгийн газрын хуралдааны 223 тэмдэглэлээр үүрэг чиглэл өгсөн 1565 заалт, Засгийн газрын 17 албан даалгаврын 669 заалт, Ерөнхий сайдын 96 захирамжийн 114 заалт, нийт 910 шийдвэрийн 3558 заалтын хэрэгжилт дунджаар 73.54 хувьтай байна.
			Бүрэн хэрэгжүүлж, хяналтаас хассан заалтын тоо	Тооцох	T+-	2025 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, тухайн шийдвэр хүчингүй болсон зэрэг шалтгаанаар 1111 шийдвэрийн 3412 заалтыг "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-ийн хяналтаас хасах үндэслэлтэй гэж салбарууд дүгнэсэн байна.
			Өмнөх тайлант хугацаанаас хойш өссөн хэрэгжилтийн хувь	Тооцох %	T%+	Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /new.unelgee.gov.mn/-д бүртгэлтэй 1348 шийдвэрийн 5688 заалтын хэрэгжилт дунджаар 73.98 хувьтай байна. Энэ нь 2024 оны мөн үетэй харьцуулахад 2 хувиар, 2025 оны хагас жилийнхээс 15.1 хувиар өссөн байна.
11.2.	Иргэн, хуулийн этгээдээс Засгийн газар, Ерөнхий сайд, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн, өргөдөл гомдлын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг боловсруулах	-	Өргөдөл, гомдлын бүрэн шийдвэрлэлтийн хувь	Тооцох %	T+5%	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны тайланг мэдээг хянаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Засгийн газрын 17 дугаар хуралдааны 12.2 дугаар тэмдэглэлийг албажуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна.
			Асуудал шийдвэрлэхтэй холбоотой баталсан шийдвэрийн тоо	4	2	Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүд, Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газраас төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг яам, агентлагийн байдлаар нэгтгэн Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.
11.3.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэлд тулгуурлан технологийн дэвшлийг ашиглан, мэдээллийг боловсруулж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах	30.0 сая.төг	Технологийн дэвшил ашигласан байдал, хувь	-	100%	Ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэхэд технологийн дэвшлийг ашиглах талаар Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолын 4-т "хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглан дүн шинжилгээ хийх" үүрэг өгөгдсөн. Үүний дагуу Улсын Их Хурлын тогтоол, байнгын хорооны тогтоолд хиймэл оюун ухаан ашиглан анализ дүгнэлтийг гаргасан тайланг Улсын Их Хурлын 7 байнгын хороонд журамд заасан хугацаанд танилцуулсан болно. Мөн Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн тайланг хиймэл оюун ухаанд суурилсан аргачлалаар хянаж, баримт бичгийн уялдаа, хэрэгжилтийн түвшин болон тайлангийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг шинжилж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигласан.
			Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийн хөгжүүлэлтийн явц, хувь	5%	5.5%	Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим системийн дараагийн шатны хөгжүүлэлтийг хариуцагч компаниар гүйцэтгүүлж хиймэл оюунаар дүн шинжилгээ хийлгэх зэрэг орчин үеийн технологийн дэвшлүүдээр хөгжүүлэлт хийж 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахим санг тайлан авахаар нээсэн болно. Шинэ систем ашиглалтад оруулсантай холбогдуулан Тэргүүн дэд даргаар ажлын даалгавар батлуулан гэрээ хийх үйл ажиллагаа явагдаж байна.
ЗОРИЛГО 5. ОРЧИН ҮЕИЙН ШААРДЛАГАД НИЙЦСЭН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ.			ХҮРЭХ ҮР ДҮН: - ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ БОДИТ ХЭРЭГЦЭЭНД ТУЛГУУРЛАСАН, ДАВХАРДАЛГҮЙ, ЧАНАРТАЙ БОЛСОН БАЙНА. - САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ӨМЧ ХАДГАЛАЛТ, ТӨРИЙН ЁСЛОЛ, ПРОТОКОЛ, ТӨРИЙН ОРДНЫ ДЭГ ЖУРАМ ЗЭРЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ ШИНЭЧЛЭГДЭНЭ.			
Зорилт.12.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайдын ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулна.	-	Бэлтгэл хангаж зохион байгуулсан ёслолын үйл ажиллагааны нийт тоо	385	Тухай бүр, гүйцэтгэлээр	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайдын ёслол хүндэтгэлийн арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажилласан.

12.1.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын гадаад улсад хийх дээд, өндөр түвшний айлчлал, олон улсын арга хэмжээний ёслолын арга хэмжээг холбогдох журам, хэм хэмжээнд нийцүүлэн зохион байгуулах	-	Гадаад улсад зохион байгуулсан ёслолын арга хэмжээний тоо	11	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга нарын гадаад улсад хийсэн 2 удаагийн айлчлалын арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган, ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2026 оны 04 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсад хийсэн төрийн айлчлал; - Монгол Улсын Их Хурлын дарга Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Коммунист намын урилгаар тус улсын Бээжин хотноо 2026 оны 03 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд хийсэн айлчлал зэрэг болно. <p>Гадаад улсад хийх өндөр дээд түвшний айлчлал, олон улсын арга хэмжээнд оролцохтой холбогдон гарсан төсвийн гүйцэтгэлийг Санхүү, хөрөнгө оруулалтын газраас гаргаж, Төсвийн шууд захирагчийн данс бүртгэлд тусгасан.</p>
			Төрийн өндөрлөгийн олон улсын арга хэмжээнд оролцсон тоо	5	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын болон Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Тэргүүн дэд даргын оролцсон дараах арга хэмжээний бэлтгэл ажлыг ханган, ёслолын арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн оролцсон Бүгд Найрамдах Казахстан Улсын нийслэл Астана хотод 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан Экологийн асуудлаарх бүс нутгийн дээд түвшний уулзалт; - Улсын Их Хурлын даргын оролцсон 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр шатрын Ази тивийн 2026 оны аварга шалгаруулах тэмцээний нээлтийн ажиллагаа; - Ерөнхий сайдын оролцсон 2026 оны 06 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд БНХАУ-ын Далай хотод зохион байгуулагдсан "Зуны Давос 2026" Давосын Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт зэрэг болно. <p>Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын Шинэ Зеланд Улсад ажиллах үеэр ашиглагдах бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэх болон Тэргүүн дэд даргын оролцсон АНЭУ-ын Дубай хотод 2026 оны 02 дугаар 02-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Дэлхийн Засгийн газруудын дээд хэмжээний уулзалт 2026" арга хэмжээний үеэр ашиглах бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэж, бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p>
12.2.	Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг хууль тогтоомж, журам, үндэсний ёс заншилд нийцүүлэн зохион байгуулах	-	Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааны тоо	18	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>1.Тайлант хугацаанд төрийн өндөр албан тушаалтанд гадаад орны зочид, төлөөлөгчид бараалхах, өндөр хэмжээний уулзалтын дараах ёслолын арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 24 удаагийн бараалхалт болон уулзалт; - Монгол Улсын Их Хурлын даргын 13 удаагийн бараалхалт болон уулзалт; - Монгол Улсын Ерөнхий сайдын 32 удаагийн бараалхалт болон уулзалт; - Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарын 9 удаагийн уулзалт; - Монгол Улсын Шадар сайд нарын 23 удаагийн уулзалт; - Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын 8 удаагийн уулзалт зэрэг болно. <p>2.Нийтээр тэмдэглэх болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн ёслолын арга хэмжээнд төрийн өндөр албан тушаалтнуудыг оролцох үеэр бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын XVII жарны "Сүрээр дарагч" хэмээх гал морин жилийн Цагаан сарын баярын өдрүүд; - Үндсэн хуулийн өдөр-2026.01.13; - Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр-2026.03.08; - Монгол цэргийн өдөр-2026.03.18; - Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр-2026.06.01-ний өдөр зэрэг болно. <p>3.Төрийн ёслолын дараах бусад арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох тухай захирамжид гарын үсэг зурах ёслолыг 2026.04.04-ний өдөр; - Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа болон тамга солилцох ёслолыг 2026.04.04-ний өдөр; - Монгол Улсын Ерөнхийлөгчид гадаад улсаас Монгол Улсад суух Элчид сайд нар Итгэмжлэх жуух бичиг өргөн барих ёслолыг;

						<p>- Төрийн тахилгат Их Богд хайрхан уулын тэнгэрийг тахиx төрийн тахилгын ёслолыг 2026.06.03-ны өдөр,</p> <p>- Отгонтэнгэр хайрхан уулын тэнгэрийг тахиx төрийн тахилгын ёслолыг 2026.06.17-ны өдөр зохион байгуулахад бэлтгэл ажлыг ханган ажилласан.</p> <p>4.Тайлант хугацаанд төрийн өндөр албан тушаалтнуудын өдөр тутмын үйл ажиллагааны ёслолын арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхийлөгчийн 79 удаагийн арга хэмжээ; - Улсын Их Хурлын даргын 23 удаагийн арга хэмжээ; - Ерөнхий сайдын 45 удаагийн арга хэмжээ; - Шадар сайдын 1 удаагийн арга хэмжээ; - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 1 удаагийн арга хэмжээ зэрэг болно. <p>Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ажлын албадын 25 удаагийн төрийн хүндэтгэлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд зориулсан зүйлсийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж, гүйцэтгэлд хяналт тавьж бүртгэлд тусган тайлагнасан.</p> <p>Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг хууль тогтоомж, журам, үндэсний ёс заншилд нийцүүлэн зохион байгуулахад гарсан зардлыг төсвийн шууд захирагчийн тайлан тэнцэлд тусган ажилласан.</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 26 хүсэлт, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн 80 гаруй албан бичгүүдийг тухай бүр хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлэж, эрх бүхий албан тушаалтан төрийн ордонд гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзалт хийх зөвшөөрөл 582, Төрийн туганд хүндэтгэл үзүүлэх зөвшөөрөл 139, нисэх онгоцны буудлын Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх зөвшөөрөл 541, эмгэнэлийн бичгийг боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх зөвшөөрөл 11-ийг тус тус олгосон байна.</p>
12.3.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Шадар сайдыг орон нутагт ажиллахад дагалдан явах, ёслол хүндэтгэлийн ажиллагааг зохион байгуулах	-	Орон нутагт зохион байгуулсан ёслолын арга хэмжээний тоо	25	7+	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Шадар сайд нарын орон нутагт ажилласан 31 арга хэмжээ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын орон нутагт ажилласан 4 арга хэмжээний ёслол, хүндэтгэлийн ажиллагаа буюу нийт 35 арга хэмжээний бэлтгэлийг тухайн орон нутагт урьдчилан очиж ханган, арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ерөнхийлөгчийн Хэнтий, Дундговь, Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Төв аймаг болон Улаанбаатар хотын Багануур, Багахангай, Налайх дүүрэг зэрэг 11 аймаг, дүүрэгт ажилласан арга хэмжээ; - Улсын Их Хурлын даргын Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ, Дархан, Орхон, Булган, Хөвсгөл, Ховд зэрэг 12 аймагт ажилласан арга хэмжээ; - Ерөнхий сайдын Хөвсгөл, Дорноговь, Төв аймгийн Эрдэнэсант сум, Өмнөговь, Дархан-Уул, Булган, Сэлэнгэ зэрэг 7 аймагт ажилласан арга хэмжээ; - Монгол Улсын Шадар сайдын Дархан-Уул аймагт ажилласан арга хэмжээ; - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын Завхан, Увс, Говь-Алтай, Ховд 4 аймагт ажилласан арга хэмжээ зэрэг болно. <p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарын 23 удаа орон нутагт ажиллах үеэр ашиглагдах бэлэг_дурсгалын зүйлийг батлагдсан төсвийн дагуу тухай бүр бэлтгэж, холбогдох санхүүгийн баримтыг бүрдүүлэн ажилласан.</p>
12.4.	Монгол Улсын Ерөнхийлөгч нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр төрийн дээд цол, одон, медалиар шагнах асуудлыг судалж шийдвэрлэх, шагнал гардуулах ёслолын	-	Зохион байгуулсан шагналын ёслолын арга хэмжээний тоо	32	Тухай бүр, гүйцэтгэлээр	Төрийн дээд одон медаль, цол гардуулах Ерөнхийлөгчийн 55 удаагийн, Улсын Их Хурлын даргын 2 удаагийн, Ерөнхий сайдын 2 удаагийн, Шадар сайдын 2 удаагийн ёслолын арга хэмжээ буюу нийт 61 удаагийн арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулсан.
			Шагнах асуудлыг судалж, хянасан тоо	3548	500+	Төрийн дээд шагналд нэр дэвшигч нийт 1396 иргэний материал (13,079 хуудас)-ыг хянаж, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан. Тухайлбал, Хөдөлмөрийн хүндэт медаль 654, Алтан гадас одон 415, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 141,

	ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх					Цэргийн гавьяаны одон 1, Сүхбаатарын одон 2, Монгол Улсын гавьяат цол 149, Төрийн соёрхолт 10, Ардын багш 2, Ардын жүжигчин 12, Хөдөлмөрийн баатар 1 байна. Мөн “Засгийн газрын Хүндэт өргөмжлөл” шагналд нэр дэвшүүлэх албан хаагчийн холбогдох мэдээлэл, материал ирүүлэх талаар 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ХЭГ/1890 дугаартай албан бичгээр яамдад хүргүүлсэн. Яамдаас ирүүлсэн материалыг холбогдох журмын дагуу хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
12.5.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, айлчлал, уулзалт, хэлэлцээрийг хуульд нийцүүлэн зохион байгуулж, гадаад томилолтын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх	-	Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан уулзалт, хэлэлцээрийн тоо	22	Тухай бүр, гүйцэтгэлээр	<p>1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхий сайдын зөвлөх болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын түвшинд олон улсын байгууллага, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөлтэй нийт 14 удаагийн уулзалт, хэлэлцээг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>1.НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч Матилда Димовскатай хийсэн 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн уулзалт;</p> <p>2.Орано Майнинг компанийн гүйцэтгэх захирал Ксавье Сан Мартан Тийетэй хийсэн 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн уулзалт;</p> <p>3.Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжоантай хийсэн 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн уулзалт;</p> <p>4.Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрхэмсэг ноён Атул Малхари Готсурветэй хийсэн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн уулзалт;</p> <p>5.Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ина Марчюленитетэй хийсэн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн уулзалт;</p> <p>6.“Бадрах Энержи” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Коралин Принтэй хийсэн 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн уулзалт;</p> <p>7.НҮБ-ын суурин зохицуулагч Яков Ван Хиердэнтэй хийсэн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн уулзалт;</p> <p>8.2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “САУС ГОБИ СЭНДС” ХХК-тай төрийн зээмшлийн хувь хэмжээг тогтоох тухай хийсэн уулзалт зэрэг болно.</p> <p>Мөн Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны VIII хуралдааны зохион байгуулалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>2.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2026 оны 04 дүгээр сарын 21–22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хамтын хөгжлийн төлөөх дэлхийн хэмжээний үйл ажиллагааны форум”-ын өндөр түвшний гуравдугаар хурлын нээлтийн үйл ажиллагаанд үг хэлж оролцох, мөн БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороо, Хөдөө аж ахуй, хөдөө тосгоны яам, Гаалийн ерөнхий газар, “Чайна Энержи” компанитай хийх албан уулзалтуудын бэлтгэл ажлыг хангасан. Улс төрийн нөхцөл байдлын улмаас уг айлчлал хойшлогдсон.</p> <p>3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын нийт 15 албан хаагчийг АНУ, БНХАУ, БНЭУ, АНЭУ, БНКааУ, ХБНГУ, Япон Улсад зохион байгуулагдсан сургалт, арга хэмжээнд оролцуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангаж, гадаад албан томилолтын тушаал, шийдвэрийг боловсруулж, албажуулсан.</p> <p>4.Ерөнхий сайд, Шадар сайдын Ажлын алба болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын нийт 11 албан хаагчийн дипломат болон албан гадаад паспортын хүсэлтийг холбогдох журмын дагуу уламжлан шийдвэрлүүлсэн.</p> <p>Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2026 оны 04 дүгээр сарын 15–24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Хөгжиж буй орнуудад шинэ чанарын үйлдвэрлэх хүчин цогцлоох нь” сургалтад Дорнод, Завхан, Архангай аймгийн Засаг дарга нарыг хамруулсан.</p>

						<p>Мөн Япон Улсын Гадаад хэргийн яам болон Япон сангийн хамтарсан тэтгэлгээр хэрэгжиж буй 8 сарын хугацаатай япон хэл, соёлын хөтөлбөрт Монгол Улсаас нэг төрийн албан хаагчийг хамруулсан.</p> <p>Гадаад улс болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтын хүрээнд Төсөл, хөтөлбөр, гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Э.Цэнгүүн Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайдын яамны Дэд тэргүүн болон холбогдох албан тушаалтнуудтай хоёр талын уулзалтуудыг зохион байгуулсан.</p> <p>Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Монгол - Японы Ирээдүй Сан хооронд байгуулахаар төлөвлөж буй Хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичгийн англи, монгол хэл дээрх төслийг боловсруулахад зохион байгуулалтын болон мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажилласан.</p>
Зорилт.13.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, чадварлаг, бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлнэ.	-	Өндөр бүтээмж, ур чадвар бүхий албан хаагчдыг томилох, дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50%+	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, чадварлаг, бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлж ажилласан.
13.1.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нийцүүлэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлуулах, сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулах	-	Ажлын хэрэгжилтийн хувь	60%	100%	Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан нийт газар, хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг өөрчлөн боловсруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Шинээр батлуулах, шинэчлэх, өөрчлөлт оруулах шаардлагатай албан тушаалын тодорхойлолтын жагсаалтыг гаргаж байна.
			Сул орон тооны нийт ажлын байранд эзлэх хувь	8.7%	4.4%	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдах албан тушаалын 2 сул орон тоог нөхөхөөр 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, гүйцэтгэх албан тушаалын 1 сул орон тоог нөхөхөөр 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус Төрийн албаны зөвлөлийн https://csc.gov.mn/ цахим хуудас болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын https://cabinet.gov.mn/ цахим хуудаст Төрийн албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах зарыг байршуулсан. Уг зарын дагуу шаардлагад нийцсэн материал ирүүлээгүй тул Төрийн албаны зөвлөлд сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлуулахаар 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/1926 дугаартай, 06 дугаар сарын 15-ны өдрийн ХЭГ/2066 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд албан хаагчдыг ажилд томилох, ажлаас чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулахтай холбоотой нийт 251 тушаал, шийдвэрийг боловсруулж, албажуулсан. Үүнээс 137 албан хаагчийг ажилд томилох, 9 албан хаагчийг шилжүүлэн томилох, 7 албан хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилох, 17 албан хаагчийг албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, 77 албан хаагчийг ажлаас чөлөөлөх, 3 албан хаагчийг чөлөөлөн шилжүүлэх, 1 албан хаагчийг сэлгэн шилжүүлэх тушаал, шийдвэрийг тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026.05.05-ны өдрийн 35 дугаар тушаалаар Албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тоо, ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан албан тушаалын дагуу Тэргүүн дэд даргын 2026.05.19-ний өдрийн 326 дугаар тушаалаар албан хаагчдыг албан тушаалаас чөлөөлж, албан тушаалд томилсон.</p>
13.2.	Төрийн албан хаагчдын богино, дунд хугацааны мэргэшүүлэх болон зорилтот сургалтын арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	-	50%	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийн төсөлд газар, хэлтсүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусган боловсруулж, "Сургалтын хөтөлбөрийг батлах тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 26 дугаартай тушаалаар батлуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнд:

						<p>-Албан хаагчдад мэдээлэл олгох сургалтыг 3 удаа зохион байгуулж, Ерөнхий сайдын Ажлын алба болон байгууллагын албан хаагчдад хиймэл оюун ухааны хэрэглээний 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>- Удирдлагын академийн эрхэлсэн болон тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5 албан хаагчийг сургахаар нэр хүргүүлж, гэрээ байгуулж, сургалтад хамруулж ажилласан. Сургалтад хамруулах шаардлагатай, хүсэлт ирүүлсэн 5 албан хаагчийг бүрэн хамруулсан.</p> <p>- Мөн Монгол Улс дахь уул уурхайн менежментийн чиглэлээр 3 албан хаагчийг сургалтад хамруулахаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин сайдын яаманд албан бичиг хүргүүлж, албан хаагчдыг 2026 оны 6 дугаар сард сургалтад хамруулсан.</p>
13.3.	Албан хаагчдын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх	-	Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	50%+	<p>Албан хаагчдын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн баталгааг хангах хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:</p> <p>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төслийг боловсруулж, газар, хэлтсүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусган боловсруулж, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 27 дугаартай тушаалаар батлуулсан.</p> <p>- Тэргүүн дэд даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 33 дугаар тушаалаар албан хаагчдын цалинг, 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 390 дүгээр тушаалаар албан хаагчдын цалин, нэмэгдлийг тус тус шинэчлэн тогтоосон.</p> <p>- Тэргүүн дэд даргын 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгууллагын эмэгтэй албан хаагчдад Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан мөнгөн урамшуулал олгож, 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 325 дугаар тушаалаар албан хаагчдад хүүхдийн баярын бэлгийн мөнгөн тусламж үзүүлсэн.</p> <p>- Тэргүүн дэд даргын 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 304 дүгээр тушаалаар албан хаагчид олгох хоол, унааны зардлын нөхөх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон.</p> <p>- Албан хаагчдаас орон сууцны нөхцөлийн судалгааг 05 дугаар сарын 13-наас 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд цахимаар авсан бөгөөд судалгаанд нийт 139 албан хаагч хамрагдсан. Судалгааны нэгтгэн, дүгнэлтийн танилцуулгыг удирдлагад эхний байдлаар танилцуулан ажиллаж байна.</p> <p>- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар нэр бүхий 9 албан хаагчид дэс, ахлах түшмэлийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон.</p> <p>- Мөн 6 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 721 дугаар албан бичгийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 118 дугаар захирамжаар 3 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон.</p> <p>- Улсын хоёрдугаар төв эмнэлэгт үзүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах 276 албан хаагчийн мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Х/207 дугаартай албан бичгээр 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн. Мөн тус эмнэлэгт үзүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах 193 албан хаагч болон тэдгээрийн гэр бүлийн мэдээллийг 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар шинэчлэн гаргаж, хүргүүлэв.</p> <p>- Хэрэг эрхлэх газрын албан хаагчдыг Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран 2026 оны 04 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулсан. Тус үзлэгийн хүрээнд лабораторийн шинжилгээнд 140 албан хаагчийг, багц үзлэгт 110 албан хаагчийг хамруулсан.</p>
13.4.	Байгууллагын соёлыг дээшлүүлэх, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Мэдээллийн цаг - 12 удаа	6	Албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зорилгоор спорт, соёл, олон нийтийн арга хэмжээнд оролцоог тогтмол дэмжин ажилласан.

						<p>Тухайлбал, 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан “Мөнгөн өвөл” цасны баяр арга хэмжээнд албан хаагчдыг амжилттай хамруулж оролцуулсан бөгөөд “2026 Марафон” арга хэмжээнд албан хаагчид өөрсдийн сонирхлын дагуу нэгдэн идэвхтэй оролцсон.</p> <p>Байгууллагын албан хаагчдад ажлын 3 өдөр, 12:00-13:30 цагийн хооронд йогийн сургалт зохион байгуулж, 8-12 албан хаагч тогтмол хамрагдаж байна.</p> <p>Мөн албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн дүнтэй уялдуулан байгууллагаас зохион байгуулж буй спорт, биеийн тамирын арга хэмжээнд оролцоог дэмжих, мэдээллээр хангах болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Албан хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2026 оны эхний улиралд нийт 3 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем”-ийн хэрэглээ, “Стресс менежмент”, Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлан хэрэгжүүлж буй “Цэгцрэх” хөдөлгөөний талаарх сургалтуудыг тус тус зохион байгуулж, албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн.</p> <p>Албан хаагчдын цаг ашиглалт, цагийн бүртгэлийн талаарх мэдээллийг байгууллагын дотоод удирдлагын цахим сүлжээ Эйбл системээс гаргаж, нэгжийн дарга нар болон байгууллагын удирдлагад 3 удаа танилцуулсан.</p> <p>Мөн албан хаагчдын цаг ашиглалт, цагийн бүртгэлийг сайжруулах хүрээнд албан хаагчдыг нүүрээр таних төхөөрөмж суурилуулж, албан хаагчдын цаг ашиглалтын байдалд хяналт тавин ажиллаж байна.</p>
13.5.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахмадын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх	-	Дэмжлэг туслалцаа үзүүлсэн эсэх	тийм	тийм	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахмадын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцааг тогтмол үзүүлж, дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Үүнд:</p> <p>- Ахмадын хороонд бүртгэлтэй 2 ахмад ажилтны эрүүл мэндийн шалтгаанаар гаргасан хүсэлт, 3 ахмад ажилтны амьдарч буй байшин, орон сууцаа засварлах талаар гаргасан хүсэлтийг үндэслэн 5 ахмад ажилтанд, нас барсан 1 ахмад ажилтны ар гэрт буцалтгүй тусламжийг тус тус үзүүлсэн.</p> <p>- 2026 оны Цагаан сарын баяраар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэх талаарх тушаал шийдвэрийг боловсруулан гаргаж, арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>- Мөн Ахмадын хорооноос ахмад настны хөгжил, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын “Сэлэнгэ” амралтад 2026.06.10-11-ний өдрүүдэд зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, Тэргүүн дэд даргын 2026.05.25-ны өдрийн 353 дугаар тушаалаар холбогдох зардлыг Ахмадын сангаас гаргасан. Уг арга хэмжээнд нийт 29 ахмад оролцсон.</p>
Зорилт.14.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дотоод үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зарим үйл ажиллагаанд дижитал шилжилт хийнэ.	-	Дотоод процессын цахимжилтын хувь	50%	55%	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дотоод үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, албани хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем (www.pm.hrs.gov.mn)-д цахим шилжилт хийсэн.
14.1.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, хиймэл оюун ухааны хэрэглээг нэвтрүүлж, шийдвэр гаргах үйл явц, хяналтыг сайжруулах	20.0 сая.төг	Хиймэл оюун ухааны хэрэглээний дундаж хувь	-	40%+	Ерөнхий сайдын Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын Ажлын алба болон албан хаагчдад хиймэл оюун ухааны хэрэглээний сургалтыг зохион байгуулж, хэрэгцээ, мэдлэгийн түвшин болон одоогийн ашиглалтын байдлыг тодорхойлох зорилгоор ажилтнуудаас дэлгэрэнгүй судалгаа авч сургалтын агуулгыг боловсруулсан. Энэ хүрээнд 10 ширхэг GPT Pro лиценз худалдан авч, Ерөнхий сайдын Ажлын алба болон байгууллагын албан хаагчдад хуваарилан ашиглуулсан бөгөөд хиймэл оюун ухааны хэрэглээний 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан.
14.2.	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу	-	Албан хэрэг хөтлөлтийн үйл	50%	60%	1.Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн), Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын

	зохион байгуулах, хяналт тавих, дижитал шилжилт хийх, тайлагнах		ажиллагааны цахимжилтын хувь			<p>асуудал эрхэлсэн), Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Тэргүүн дэд дарга, газар, хэлтсийн дарга нарт байгууллага, албан тушаалтнуудаас ирсэн 8578 (Нууцын зэрэглэлтэй 276, илээр ирсэн 7132 албан бичиг, 1170 өргөдөл) албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн, холбогдох албан хаагчид шилжүүлж, шийдвэрлэлтийн явцад тогтмол хяналт тавьж, тайлагнаж ажиллав.</p> <p>2.Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн)-ын ажлын албад болон ЗГХЭГ-аас явуулж буй 3750 албан бичиг (ил 3689, нууцын зэрэглэлтэй 61 албан бичиг)-ийн стандарт, бүрдлийг хангуулж, бүртгэж, цаасаар болон цахимаар холбогдох байгууллага, албан тушаалтанд илгээсэн.</p> <p>Явуулах баримт бичгийн монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад тогтмол хяналт тавьж, зөрчлийг арилгуулан хүргүүлсэн.</p> <p>3.Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын 120, Монгол Улсын Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн)-ын 34, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 52, Тэргүүн дэд даргын 374, нийт 580 тушаалын бүрдэл, стандартыг хянаж, дугаар олгосон байна. Стандартын зөрчилтэй болон үг, үсгийн алдаатай 26 тушаалын зөрчлийг арилгуулсан болно.</p> <p>Түүнчлэн, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл хуудсыг "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага (MNS 6395:2022)"-д нийцүүлэн хэвлүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Тайлангийн хугацаанд Монгол Улсын Шадар сайд нар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Тэргүүн дэд даргын нийт 148 тушаалыг монгол бичигт хөрвүүлж, тушаалын нэгдсэн сан үүсгэж, зөв бичих дүрэм болон стандартын шаардлагыг хангаж ажиллав.</p> <p>4.Тайлангийн хугацаанд нийт 11231 хэвлэмэл хуудас (Шадар сайдын тушаал-530, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал-150, Тэргүүн дэд даргын тушаал-1000, ЗГ албан бичиг-2580, ХЭГ, Х албан бичиг-6971) ашигласан байна.</p> <p>5.Нийт ирсэн бичгийн 40 хувь, явсан бичгийн 90 хувь цахимжсан байна.</p>
14.3.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын сүлжээ, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байнгын ажиллагааг хангах	-	Шинэчлэл хийсэн техник, тоног төхөөрөмж, хувь	60%	70%	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийн 5 төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, техник тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг хийж, комисс томилон хүлээн авч, хуваарилах, бүртгэлийн ажлыг зохион байгуулж байна.
14.4.	Байгууллага, нэгжүүд, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем"-д оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллав	-	Систем нэвтрүүлэлт, ашиглалтын хувь	-	90%+	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем нэвтрүүлэх ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн. Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг системд оруулж, албан хаагчдад системийн талаар байгууллагын нийт албан хаагчдад сургалт хийж, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээ.
			Төлөвлөгөөг системд оруулж баталгаажуулсан хувь	-	100%	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем (www.pm.hrs.gov.mn)-ийн нэвтрүүлэлт, ашиглалт 100 хувь байна.
			Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	50%+	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем (www.pm.hrs.gov.mn)-д оруулах ажлыг гүйцэтгэж, нийт 11 нэгж, 119 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулах, баталгаажуулах үйл ажиллагааг цахим системээр бүрэн хэрэгжүүлж, нийт албан хаагчид, нэгжийн төлөвлөгөөг 100 хувь батлуулсан.
						Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон бодлогын бусад баримт бичиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд туссан арга хэмжээг тусган Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын

						Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 89 хувьтай байна.
14.5.	Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хиймэл оюун ухаанаар давхар үнэлж, дүгнэх шийдлийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх	-	Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг хиймэл оюунаар үнэлсэн хувь	-	100%	2025 оны албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээнд хиймэл оюун ухаанд суурилсан давхар үнэлгээг хийж туршсан бөгөөд энэхүү аргачлалыг 2026 оны эхний 3 сарын гүйцэтгэлийн үнэлгээний дүн шинжилгээнд туршилт хэлбэрээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнг удирдлагад танилцуулсан.
14.6.	"Ухаалаг засаг-II" төслийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагаанд дижитал шилжилт хийх, тоног төхөөрөмж шинэчлэх төслүүдийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийн тайлан гаргах, хэрэгжилтийг хангуулах	-	Төслийн хэрэгжилтийн дундаж хувь	10%	40%	Тайлант хугацаанд сургалтын нэгдсэн цахим платформ (surgalt.gov.mn)-ийг өргөтгөн хөгжүүлэх, Засгийн газрын цахим болон танхимын хуралдааны дижитал шилжилт хийх тоног төхөөрөмжийн шинэчлэл, Засгийн газрын архивыг цахимжуулах зэрэг нийт 4 чиглэлийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон, төслийн баримт бичгийг боловсруулж худалдан авах ажиллагаа болон гэрээний зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн. Сургалтын платформын хөгжүүлэлтийн гэрээний хэрэгжилтийг хянаж, тайлант ажлыг хүлээн авч системийн ажиллагааг шалган холбогдох байгууллагуудад танилцуулсан. Мөн Засгийн газрын архивын тоног төхөөрөмжийн шинэчлэлийн төслийг бүрэн хэрэгжүүлж, 42 төрлийн 385 тоног төхөөрөмжийг хүлээн авч суурилуулан гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.
			Хэрэгжүүлэх төслийн тоо	6	6	
14.7.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хүлээн авч хянан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, тайланг дүгнүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	100%	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа байгууллага болох Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар болон Ерөнхий сайдын харьяа байгууллага болох Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хүлээн авч, Сайдаар хянан батлуулж, батлагдсан төлөвлөгөөг хүргүүлэн ажилласан. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяа байгууллагад ханган ажиллаж байна. Харьяа байгууллагаас албан бичгээр ирүүлсэн асуудлыг тухай бүр шийдвэрлэж, үйл ажиллагаанд нь шаардлагатай зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газраас албан бичгээр ирүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, хамтарсан захирамж/тушаалаар журмын заалт хүчингүй болгох, Төрийн банкны салбар ажиллуулах, цахилгаан хязгаарлах талаар, дэмжлэг хүсэх тухай, хамтран ажиллах талаар хүсэлтийг тухай бүр шийдвэрлүүлж, үйл ажиллагаанд нь зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай Засгийн газрын байруудын өрөө тасалгааны асуудлаар хамтран санал, мэдээлэл солилцож, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
14.8.	Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх	-	Хугацаанд нь шийдвэрлэсэн хувь	Албан бичиг-3118 Өргөдөл, гомдол, санал 412+	Хууль заасан хугацаанд шийдвэрлэх хувь 98+%	1.Тайлангийн хугацаанд (2026.06.10-ны өдрийн байдлаар) Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн), Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн), Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Тэргүүн дэд дарга, газар, хэлтсийн дарга нарт байгууллага, албан тушаалтнуудаас ирсэн 7372 албан бичиг, 1201 өргөдөл, гомдлыг хүлээн авсан байна. Үүнээс 4307 хариутай албан бичиг, 3065 хариугүй албан бичиг ирсэн бөгөөд хариутай ирсэн бичгийн 93.55%-ийг шийдвэрлэсэн байна. Тайлангийн хугацаанд иргэн, хуулийн этгээд, албан хаагчдаас ирүүлсэн 1201 өргөдөл, гомдол, ирүүлснийг хүлээн авч, зохих журмын дагуу санал боловсруулан удирдлагад танилцуулж, 1072 (89,33%) өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд 102 өргөдөл, гомдол хяналтад судлагдаж байна. Хариуцсан асуудлын дагуу 3792 албан бичгийг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагад цахим болон цаасаар хүргүүлсэн байна.
14.9.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дотоод журмын дагуу Засгийн газрын хуралдааны болон мэдээ, тайлан, баримтуудыг нэгж, албан хаагчдаас хуваарийн дагуу	-	Баримт бичгийн архивт шилжүүлсэн хувь	100%	-	Засгийн газрын 2025, 2026 оны нээлттэй болон хаалттай хуралдаанаар хэлэлцсэн нийт 414 асуудлын 25,942 хуудас баримтыг албан хаагчдаас бүрдүүлэлтээр хүлээн авч, нягтлан шалгаж, хувийн хэрэг бүрдүүлсэн. Ерөнхий сайдын ажлын алба, Шадар сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдсөн байнга, түр хадгалах нийт 758
			Архивт шилжүүлсэн баримт бичгийн нэгжийн тоо	1249	Гүйцэтгэлээр	

	хугацаанд нь бүрэн шилжүүлэн авах					хадгаламжийн нэгжийг Засгийн газрын архивд бүрдүүлэлтээр хүлээн авсан. Үүнээс: Байнга хадгалах хадгаламжийн нэгж 298, түр хадгалах хадгаламжийн нэгж 460 байна.
14.10.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, албан тушаалтан болон холбогдох бусад байгууллагын удирдлагыг шуурхай мэдээлэл, зохион байгуулалтаар хангах	-	Холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээллийг цаг алдалгүй хүргэж, шуурхай зохицуулалт хийх хувь	95%+	95%+	Засгийн газрын хуралдаан болон бусад хурал, зөвлөгөөний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, яаралтай 41 албан бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэж, Засгийн газрын 37 шийдвэр (Засгийн газрын 34 тогтоол, Ерөнхий сайдын 3 захирамж)-ийг яаралтай албажуулж, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг шуурхай зохицуулж ажилласан. Улс орны цаг үеийн шинжтэй, тулгамдсан асуудлыг талаарх мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагуудаас цаг алдалгүй авч нягтлан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, албан тушаалтан болон холбогдох бусад байгууллагын удирдлагыг шуурхай мэдээлэл, зохион байгуулалтаар ханган ажилласан. Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн шуурхай штабаас ирсэн хоногийн мэдээ мэдээллийг бэлтгэн 150 удаа байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан байна.
14.11.	Төрийн байгууллага, албан тушаалтан, нийтийн эрх зүйн этгээдэд тамга, тэмдэг хийлгэх зөвшөөрөл олгох, хяналт тавих, тайлагнах	-	Зөвшөөрөл олгосон, буцаасан хүсэлтийн тоо	Ирүүлсэн хүсэлт-304 Зөвшөөрөл олгосон-250 Буцаасан-54	100	- Тайлангийн хугацаанд 175 байгууллагаас тамга хийлгэх хүсэлт ирүүлснийг судалж, 135 байгууллага, албан тушаалтанд зөвшөөрөл олгосон. Зөвшөөрөл олгох боломжгүй 40 байгууллага, албан тушаалтанд журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгийг хүргүүлж ажилласан. - Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу 133 байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд тамга хийлгэх зөвшөөрлийг монгол бичгээр бичиж хүргүүлсэн. Тамга хийлгэх зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтны мэдээллийн санг excel программд үүсгэн тогтмол баяжуулан ажиллаж байна.
Зорилт.15.	Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчид төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, дотоод үйлчилгээг хурдан шуурхай гүйцэтгэнэ.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх	тийм	тийм	Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчид төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, дотоод үйлчилгээг шуурхай гүйцэтгэж ажилласан.
15.1.	Төсвийн ерөнхийлөн захирагчдын болон шууд захирагчийн стратегийн зорилт, хуульд тогтоомжид нийцсэн төсвийн төлөвлөлт, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд санхүүгийн тайлан, төсвийн тайлагнал, гүйцэтгэлийг зохион байгуулах, үр ашигтай байдалд хяналт тавих	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн, ҮАГ болон бусад газрын үнэлгээний хувь (зөрчилгүй - 100%, хязгаарлалттай-70%, сөрөг - 50%, татгалзсан - 10%)	87.9%	90%	Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайд- "Өөрчлөлтгүй", Шадар сайд (ОББХ), Шадар сайд (ГХОХАА), Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багц "Хязгаарлалттай" санал, дүгнэлт авсан. Аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланг тус бүрийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн албан бичгээр Сагийн яаманд хүргүүлсэн. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр Төсвийн ерөнхийлөн захирагчдаар төлөвлөгөөг батлуулж, албан бичгээр тогтоосон хугацаанд нь Үндэсний аудитын газарт хүргүүлж тус газрын цахим системд байршуулсан. Тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын байгууллагуудаас ирүүлсэн батлагдсан төсөвт зохицуулалт хийх болон санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 54 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 24, Төсвийн шууд захирагч байгууллагуудын сар бүрийн 36 төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ бэлтгэсэн. Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон шууд захирагчийн (БСҮХ, 20МХҮХ, АХ2050ҮХ, ХҮҮХ, ЭХРҮЗБҮХ, ЭЗБЗАА зэрэг) байгууллагуудын 2025 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг гарган Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Албан хаагчдын цалин хөлс, Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, албан томилолт, хангамж, бараа материал, үндсэн хөрөнгө шаардлагатай төсөвт тусгагдсан бараа, үйлчилгээний төлбөр тооцоог Төсвийн шууд

						<p>захирагчийн байгууллагуудын харилцах дансаар төлбөр тооцоог хийн Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлэн баталгаажуулсан.</p> <p>Төсвийн шууд захирагчийн хангамж, бараа материал, үндсэн хөрөнгийн орлого, зарцуулалтыг анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавьж, гүйцэтгэлийг данс бүртгэлд тусган, 2025 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд туссан өглөгийг төлж барагдуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гарган бусад мэдээллийн хамт хугацаанд нь Шилэн дансны цахим хуудсанд байршуулав.</p> <p>Төсвийн тухай хуулийн дагуу Ерөнхий сайд, Шадар сайдууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын байгууллагуудаас ирүүлсэн 2027 оны төсвийн хязгаарын саналыг нэгтгэн тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд 06 дугаар сарын 10-ны дотор албан бичгээр хүргүүлсэн.</p>
15.2.	Хөгжлийн болон салбарын бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөөний зорилтод нийцсэн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нийгэм-эдийн засгийн үр ашигт байдал, ач холбогдлын зэргээр эрэмбэлэн төлөвлөх	-	Стратегийн төлөвлөлттэй нийцсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний хувь	70%	-	Ерөнхий сайд, Шадар сайдуудын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Улсын хөгжлийн 2027 оны жилийн төлөвлөгөөний төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд албан бичгээр тус тус хүргүүлж, харьяа байгууллагуудын Хөгжлийн төлөвлөгөөнд өгсөн төсөл, арга хэмжээг хянаж, Government Planning System v4.0 системд оруулсан.
15.3.	Өмч хөрөнгийн удирдлага, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг холбогдох стандартад нийцүүлэн хөрөнгийн бүртгэл, ангилал, үнэлгээ, тооллогыг эрхлэн зохион байгуулж, үр дүнг санхүүгийн тайлан тэнцэлд тусган, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх	-	Тооллого тооцоог тайлан тэнцэлд бүрэн тусгасан эсэх	тийм	тийм	"Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн болон 2026 оны эхний хагас жил болон жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулах тушаалыг Төсвийн шууд захирагчаар батлуулсан. Тооллогын комисс нь эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолж, баталгаажуулан зургийг авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын umch.gov.mn системд оруулах зохион байгуулсан.
			Өмч хөрөнгийг бүртгэл, тооллогод бүрэн тусгасан хувь	100%	100%	
Зорилт.16.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж эрсдэлийг бууруулна.	-	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх	тийм	тийм	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын 3 байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийсэн бөгөөд Шадар сайдын /онцгой болон гадаад худалдаа/ 2 төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг хийж байна. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
16.1.	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний тайлан, байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэж, хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагыг зөвлөгөө,	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	4	2	<p>1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан. Засгийн газрын хуралдааны 07 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>2.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн хэрэгжүүлэх 57 төсөл, арга хэмжээ батлагдсан. 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем (https://new.unelgee.gov.mn/home/)-д байршуулж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үнэлгээ 82.6 хувь байна.</p> <p>3.Монгол Улсын хөгжлийн 2025 төлөвлөгөөнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үндсэн хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээ, 7 тэргүүлэх чиглэл, 2 шалгуур үзүүлэлт батлагдсан. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хамаарах арга хэмжээнүүдийг 2025 оны жилийн эцсийн биелэлтийг Засгийн газрын</p>

						хяналт-шижилгээ, үнэлгээний цахим сан (https://new.unelgee.gov.mn)-д байршуулж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үнэлгээ 42.5 хувьтай үнэлэгдсэн байна.
			Тайлагналтын тоо	12	6	Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол болон мөн оны 183 тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын асуудлын хүрээний тайлан, байгууллагын гүйцэтгэлийн тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тухай бүр удирдлагад танилцуулсан болно. Мөн дээрх баримт бичгүүдийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар дамжуулан баталгаажуулан системд илгээж ажилласан.
16.2.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангах	-	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	4	-	1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 133 дугаар тушаалаар баталсан "Дотоод аудитын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд заасны дагуу 2026 оны 01 дүгээр удирдамж батлуулан Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2026 оны ХЭГ/1787 дугаар албан бичгээр 1,307.6 сая төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж хүргүүлж, 8 дүгнэлт, 6 зөвлөмж боловсруулан шалгалтын тайланг 2026.05.29-ний өдөр нэгжийн даргад танилцуулсан. 2.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026.01.19-ний өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2026.01.29-ний 08 дугаар тушаалаар Засгийн газрын 2025 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-ын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, журмын хэрэгжилт 72.5 хувьтай, 4 дүгнэлт, 11 санал, зөвлөмж боловсруулан нөггтлэл тайлан бичиж 2026.03.05-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад, 2026.03.06-ны өдөр зөвлөхөд танилцуулж, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэл өгсөн. 3.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны 133 дугаар тушаалаар баталсан "Дотоод аудитын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд заасны дагуу 2026 оны 02 дугаар удирдамж батлуулан Шадар сайдын /онцгой болон гадаад худалдаа/ 2 төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг ажлын 10 хоногт багтаан хийж гүйцэтгэхээр батлуулж, шалгалтыг эхлүүлсэн бөгөөд дүнг 2026.06.24-ний өдөр танилцуулахаар ажиллаж байна.
			Илрүүлсэн зөрчлийн тоо	60	-	
			Зөвлөмжийн биелэлтийн дундаж хувь	87%	-	
16.3.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх	-	Удирдамжид заасан хугацаанд хуулийн хүрээнд хийж гүйцэтгэж, танилцуулсан хяналт шалгалтын ажлын тоо	5	Гүйцэтгэлээр	1.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан 2026.01.28-ны өдрийн 01 дүгээр удирдамжаар "Хархорум хотын Захирагчийн ажлын алба болон Хархорум хотын төлөвлөлт бүтээн байгуулалтын хүрээнд хийгдсэн ажилд хяналт шалгалт хийх" үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, 2023-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж гүйцэтгэн, 518.7 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлж, 8 дүгнэлт, 8 санал боловсруулан 2026.03.04-ний өдөр нэгтгүүлсэн. 2.Монгол Улсын Шадар сайдын 2026.04.30-ны өдрийн 94 дүгээр тушаалаар "Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийх" үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, 2023-2026 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэн, 1,062.1 сая төгрөгийн 17 зөрчил илрүүлж, 6 дүгнэлт, 6 зөвлөмж боловсруулан 2026.05.12-ны өдөр дэд тайланг Шадар сайдын Зөвлөх М.Төмөрт нэгтгүүлсэн. 4.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж үзэхэд төсвийн 4 ерөнхийлөн захирагчийн 110 байгууллага нийт 5437 мэдээлэл байршуулахаас 150 мэдээллийг хугацаа хоцроож, 16 мэдээлэл байршуулаагүй, хэрэгжилт 96.9 хувьтай, 2026 оны 1-р улирлын байдлаар 4 төсвийн ерөнхийлөн захирагчийн 138

						байгууллага 1900 мэдээлэл байршуулахаас 67 мэдээллийг хугацаа хоцроож, 33 мэдээлэл байршуулаагүй, хэрэгжилт 96.0 хувьтай тайлагнасан 2 тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2026.01.23-ны өдрийн ХЭГ/243, 2026.04.24-ний өдрийн ХЭГ/1367 дугаар албан бичгээр холбогдох журамд заасны дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад тус тус хүргүүлсэн. 5.Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 2981, 3208, 3530, 3542 дугаартай албан бичгээр ирүүлсэн гүйцэтгэл-нийцлийн аудитын тайлантай танилцаж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тухай бүр төлөвлөгөөт үүрэг даалгавар хүргүүлж ажилласан. Ажлын төлөвлөгөөг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2026.01.29-ний өдрийн ХЭГ/308 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.
16.4.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хугацаанд тухай бүр тайлагнаж удирдлагад танилцуулах	-	Тайлагналтын тоо	12	6	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 7 удаагийн шуурхай үүрэг даалгаврын биелэлтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагын хуралд танилцуулж ажилласан.
			Хугацаанд тайлагнасан үүрэг даалгаварын эзлэх хувь	-	70%+	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын шуурхай үүрэг даалгаврыг байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний /igovernment.mn/ системээр үүрэг даалгаврыг хяналтад авч зохион байгуулалтын нэгжүүдийн баталгаажуулан тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үүрэг даалгаврын хэрэгжилтийн дундаж 86.0 хувьтай үнэлэгдсэн байна.